



# ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО 4: ИРГЭНИЙ НИЙГМИЙН ТОДРУУЛАГЧ ТАЙЛАН 2020–2022

Тайланг бичсэн: Ц.Мандхайхатан  
(“Бодлогод залуусын хяналт” ТББ-ын зөвлөх, хуульч)

“Боловсролын төлөө чанга дуугарцгаая!” төслийн  
дэмжлэгээр хэвлэв.

Дизайнер: Б.Тайван  
Цаасны хэмжээ: 60x84 1/12  
Хэвлэлийн хуудас: 5.5 х.х  
Хэвлэсэн тоо: Ш

## Өмнөх үг

Боловсрол эвсэл иргэний нийгмийн байгууллагын хувьд Монгол улсын төр засгаас олон улсын тавцанд авсан амлалтын улс орны түвшин дэх хэрэгжилтийг хянаж үнэлэх ёстой гэдэг итгэл үнэмшилтэй.

Тогтвортой хөгжлийн 4 дүгээр зорилго болох “Бүх хүн тэгш хамруулсан, эрх тэгш байдлыг хангасан, чанартай боловсрол эзэмших явдлыг баталгаажуулах ба бүх хүн насан туршдаа суралцах боломжийг хөхиүлэн дэмжих”-ийн явцын хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгсөн тайланг 2015 оноос хойшх хугацаанд 3 дахь удаагаа олон нийтэд танилцуулж байна.

Монгол улсын хувьд Тогтвортой хөгжлийн 4 дүгээр зорилгын хэрэгжилт бусад 16 зорилгуудтай харьцуулахад өндөр гэж харагдаж байгаа ч КОВИД-19 цар тахлын сөрөг нөлөөллөөс шалтгаалан тодорхой ухралтууд гарч буйг та бүхэнд харуулахыг хүслээ. Гэхдээ зайны сургалтад шилжиж, боловсролыг тасралтгүй олгох хүчин чармайлт гаргасны хүчээр Монгол улсын боловсролын тэгш хамруулах байдал, боловсролд эрх тэгш байдлыг хангах чиглэлээр цаашид юу хийх ёстой вэ гэдгээ бодлого боловсруулагчид, хэрэгжүүлэгчид олж харсан гэдэгт бид итгэж байна.

Тогтвортой хөгжлийн 4 дүгээр зорилгын хэрэгжилтийг “Action for Sustainable Development” буюу ТХЗ-уудын хэрэгжилтийг шаардах олон улсын санаачилгаас боловсруулсан иргэдээс оноо өгөх аргачлалын дагуу үнэлсэн байдал, түүний үндэслэлийг тайлбарласан гэсэн 2 хэсгээс уг тайлан бүтнэ. Мөн КОВИД-19 цар тахлын үеийн боловсролын салбарт тулгамдсан сорилт, бэрхшээлийг тусад нь үнэлж бичлээ.

КОВИД-19 цар тахлын үед Боловсрол эвсэл идэвхтэй ажиллаж, “Ковид 19 боловсролд үзүүлж буй нөлөө”, “Ковид 19-ын шалтгаант хөл хорионы үеийн багшлахуй, суралцахуй”, “Ковид 19 цар тахал тодорхой бүлгийн залууст хэрхэн нөлөөлсөн бэ?” судалгаанууд хийж чадсан ба эдгээр судалгаа, мониторингийн тайлангуудыг “Иргэний нийгмийн тодруулагч тайлан”-д өргөнөөр ашиглалаа. Үнэлгээ, дүгнэлт тайланг Боловсрол эвслийн гишүүдийн уулзалтаар хэд хэдэн удаа хэлэлцэж, баталгаажуулсныг дуулгахад таатай байна.

Тайланг бичихэд хувь нэмрээ оруулсан Экпат Монгол сүлжээний зохицуулагч Б.Ихтамир, Тогтвортой хөгжлийн 4 дүгээр зорилгын ерөнхий хэрэгжилтийг үнэлэх, үүнд хэрэгжүүлэх бодлого, стратегийг авч үзэх, ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд иргэний нийгэм, орон нутгийн захиргаа, донорууд болон бусад өргөн хүрээний талуудын оролцоог үнэлэх зэргээр хэрэгжилтийн үнэлгээний үндэслэл нотолгоо хэсгийг боловсруулсан зөвлөх Ц.Мандхайхатан нарт талархсанаа илэрхийлье!

*“Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн Ерөнхий зохицуулагч Д.Тунгалаг*

## ТАЙЛАНГИЙН ТУХАЙ

Даян дэлхийн хамтын алсын хараа болсон “Тогтвортой хөгжлийн зорилго” (ТХЗ) нь **нийгэм, эдийн засаг, байгаль орчин** гэсэн гурван тулгуурт суурилан тогтвортой хөгжилд хүрэх дэлхийн нийтийн урт хугацааны бодлогын баримт бичиг тул үндсэн 17 зорилго, 169 зорилт, 244 үзүүлэлттэйгээр 2015 онд батлагдсан билээ. 2016-2030 онд хэрэгжиж буй уг уг хөгжлийн зорилго хэрэгжилтээ үнэлэхэд наад зах нь 50 хувийн хэрэгжилттэй байх хугацааг үдээд байна. Гэвч 2021 онд нийтлэгдсэн “Дэлхийн Тогтвортой хөгжлийн тайлан”-гийн үзүүлэлтээр Монгол Улсын Тогтвортой хөгжлийн индекс 63.8 болж нийт 165 орноос 106-д эрэмбэлэгдсэн бөгөөд бүс нутгийн (Зүүн болон Өмнөд Ази) дунджаас доогуур байна.<sup>1</sup>

Иргэний нийгмийн энэхүү тодруулагч тайлангийн хувьд ТХЗ-ын 4 дэх зорилго болсон “Бүх хүн тэгш хамруулсан, тэгш байдлыг хангасан, чанартай боловсрол эзэмших явдлыг баталгаажуулах ба бүх хүн насан туршдаа суралцах боломжийг хөхиүлэн дэмжих”<sup>2</sup> зорилгын явцын хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгөхийг зорив. Учир нь 2019 онд “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслээс 2016-2019 онд ТХЗ-4 дэх зорилго хэрхэн хэрэгжиж буй талаар “Тодруулагч тайлан”-г эрхлэн гаргаж, эхний гурван жилд иргэний нийгмийн хөндлөнгийн дүнг хэдийн тавьсан билээ.

Энэ удаагийн үнэлгээ нь “Action for Sustainable Development”<sup>3</sup> буюу ТХЗ-уудын хэрэгжилтийг шаардах олон улсын санаачилгаас боловсруулсан арга зүйд тулгуурласнаараа онцлог. Тодруулбал, иргэдийн онооны үнэлгээ нь ТХЗ-ын хэрэгжилтийн тухай иргэдийн төсөөллийг 10 тодорхой чиглэлд судлахад суурилж, ТХЗ тус бүрийн хэрэгжилтийн явцыг улс бүрээр харуулан, дэлхийн хэмжээний мэдээллийг нэгдсэн арга зүйгээр нэгтгэн үнэлэх боломжтой болгохыг зорьсон. Иймд энэхүү тайланд онцолж буй мэдээллүүд ТХЗ-4-ийн зорилт тус бүрээр харуулахаас илүүтэй улс орны бодлого, хэрэгжилт, институцийн зохион байгуулалт зэрэг хэд хэдэн зангилаа асуудлууд ТХЗ-4-ийг хэрэгжүүлэхэд чиглэж буй эсэхийг харуулах болно.

1 “Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ 2023-2027 он” Монгол Улс, 2022 оны 5 дугаар сар, 9-р тал.

2 “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн албан бус орчуулга. Албан ёсны орчуулгад “inclusive” болон “equitable” нэр томъёоны ялгааг гаргахгүйгээр “тэгш” хэмээн буулгасан нь “бүгдийг тэгш хамруулах, хэнийг ардаа үлдээхгүй” гэсэн ТХЗ-ын утга санааг бүрэн илэрхийлж чадахгүй байна.

3 <https://action4sd.org/>

Үнэлгээний цаг хугацаа КОВИД-19 цар тахал дэлхий дахинд дэгдсэн хугацаатай давхцаж буй тул ТХЗ-ийн хэрэгжилт ухрах буюу зарим асуудал, үзүүлэлтүүд сул үнэлгээг авахад хүргэсэн. Хэдийгээр Засгийн газрын зүгээс цар тахлын сөрөг нөлөөг бууруулах, сурлагын хоцрогдлыг арилгах, боловсролын чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд тодорхой ахиц дэвшил гаргахыг зорьж буйг иргэний нийгмийн зүгээс сайшаан дэмжиж буй боловч тайлант хугацаанд хамаарах мэдээлэлд тулгуурлан, үнэлгээний арга зүйн дагуу объектив хандахыг зорьсон. Тодруулбал, энэхүү үнэлгээнд ашигласан мэдээллүүд 2020 болон түүнээс хойш нийтлэгдсэн судалгаа, шинжилгээ, мэдээллүүдийг ашиглахад онцгойлон анхаарсан болно.

## “ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО-4” КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕИЙН СОРИЛТ, БЭРХШЭЭЛ

Ковид-19 цар тахлын дэгдэлт Монгол Улсын хүний эрхийн тогтолцооны чадавхыг бүхэлд нь сорьсон томоохон сорилт болов. Ялангуяа, манай улс хүүхэд, залуучуудын улс орон болохын хувьд боловсролын салбарт хэрэгжүүлсэн цар тахлын эсрэг хариу үйлдэл, арга хэмжээ тус салбарт олон жил бугшсан, шийдвэрлэгдээгүй асуудлуудыг тод томруунаар илрүүлж, боловсролын салбарын ухралт олон жилийн сөрөг үр дагавар авчирдгийг харуулсаар байна. Тухайлбал, 2019 оны сүүлээс дэлхий дахинд дэгдэж, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 2020 оны 03 дугаар сарын 12-оос “Ковид-19” цар тахал хэмээн хүлээн зөвшөөрөхөөс өмнө, Засгийн газрын зүгээс дотооддоо халдвар тархаагүй байх үед<sup>4</sup> буюу 2020 оны 1 сарын 27-нд цэцэрлэг, сургуулиудаа хааж, хууль батлагдахаас өмнө зайн сургалтанд шилжсэн.

УИХ-аас 2020 оны 4 дүгээр сарын 29-нд “Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийг баталсан бөгөөд хугацааг нь хэд хэдэн удаа сунгаж, үйлчлэл нь 2022 оны 12 сарын 31-нд дуусгавар болохоор баталсан. Уг хуулиар боловсролын салбарт авч хэрэгжүүлэх арга хэмжээг хоёр заалтаар зохицуулсан бөгөөд эхнийх нь “бүх шатны боловсролын сургалтыг зайн хэлбэрээр зохион байгуулах” дараагийнх нь “зайн сургалтыг чанартай, хүртээмжтэй, оролцоотой” зохион байгуулахыг Засгийн газарт үүрэг болгосон. Ийнхүү хичээл сургалтын үйл ажиллагаа цар тахлын тархалтаас үл хамааран “улс төрийн шийдвэр”-ээр цахим хэлбэрт шилжив.

Энэхүү 2019-2020 оны хичээлийн жилд СӨБ-д 263,333 сурагч, ЕБС-д 640,499 сурагч, насан туршийн боловсролын 6,917 сурагч, их дээд сургуульд 148,446 оюутан сурагчид теле болон цахимаар хичээл үзэх шаардлагатай болсон.<sup>5</sup> 2020 онд 75 өдөр буюу 47 хувь, 2021 онд аймаг орон нутагт 100 өдөр буюу 62 хувь, нийслэлд 110 өдөр буюу 68 хувьтай тэнцэх хугацаанд цахим хэлбэрээр хичээллэсэнээр<sup>6</sup> БШУЯ-ны тооцоогоор

4 Манай улсад 2020 оны 3-р сарын 9-ний өдөр халдварын зөөвөрлөгдсөн анхны тохиолдол бүртгэгдэж, 11-р сарын 10-ны өдөр дотооддоо халдварын тохиолдол илэрсэн. Эх сурвалж: <https://moh.gov.mn/uploads/files/f6781dc5441b59580495f0db003972fdcae09e7b.pdf>

5 “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл, “Ковид 19 цар тахлын боловсролд үзүүлж буй нөлөө,” 2021 он, 6 дахь тал

6 “ЕБС-ийн сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах цогц төлөвлөгөө”, БШУС-ын А/190 дүгээр тушаал, Улаанбаатар, 2021 он.


174,000<sup>7</sup> хүүхэд хичээлийн хоцрогдолд өртсөн болохыг тогтоожээ.

“Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн зүгээс цар тахлын үед хэд хэдэн удаагийн баримтжуулалт, судалгаа мониторингийг хэрэгжүүлж, тухай бүрт нь тулгарсан асуудлыг БШУЯ болон холбогдох боловсролын талуудад танилцуулж, шийдвэрлүүлэхэд хувь нэмрээ оруулж ажилласан.<sup>8</sup> Ийнхүү хэрэгжүүлсэн судалгаа, шинжилгээ, ажиглалтдаа тулгуурлан “цар тахлын үеийн боловсролын бодлого, хэрэгжилтэд тулгамдсан дараах суурь асуудлыг илрүүлсэн” болохыг цохон тэмдэглэж байна. Үүнд:

## 1. Боловсролын салбарын төсвийг хуулиар хамгаалах шаардлагатайг батлав.

Боловсролын хуулийн боловсролын салбарт улсын төсвийн 20 хувиас доошгүйг зарцуулж байх тухай заалтыг хүчингүй болгосон. Ингэснээр 2000 оноос тогтмол нэмэгдэж буй улсын төсвийг дагаж, боловсролын салбарын санхүүжилт нэмэгдэх боломжийг хаав. Ялангуяа, цар тахлын үед боловсролын салбарын санхүүжилтийг хэмнэхэд хуулийн хязгаарлалт байгаагүй тул хамгийн эгзэгтэй цаг үед тус салбарын зардлыг үлэмж хэмжээгээр хэмнэснийг доорх графикаас харж болно.

График 1: Улсын нэгдсэн төсвийн зарлагад боловсролын салбарын эзлэх хувь<sup>9</sup>



- <https://ikon.mn/n/25fl> БШУЯ-ны сайд Л.Энх-Амгалан НҮБ-ын суурин зохицуулагч Тапан Мишра тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзах үеэрээ мэдэгдсэн байдаг.
- Жишээ дурдвал, “Ковид 19 боловсролын салбарт үзүүлж буй нөлөө” мониторингийн тайлан (2021 онд); “Ковид-19 шалтгаант хөл хорионы үеийн багшлахуй, суралцахуй” судалгааны тайлан (2020 онд)
- Эх сурвалж: [www.1212.mn](http://www.1212.mn); Бодлогод залуусын хяналт ТББ-ын цахим хуудсаас үзэж, дэлгэрэнгүй тоон мэдээлэл авах боломжтой: <https://www.policywatch.mn/educationbudgetdata.html>

Энэ нь боловсролын салбарыг тэргүүлэх салбар болгон хөгжүүлж, төрийн ивээлд байх зарчмын эсрэг бодлого болсон юм. Гэтэл Монгол Улс "... 2008-2009 оны дэлхийн эдийн засгийн хямралын үеэр ч боловсролын салбарын төсвийг таналгүй (бодит утгаар) улсын төвсийн хамгийн том хэсэг болох 18.9 хувийг зарцуулж байсан, эдийн засаг уналтад орсон 2015-2016 онд ч төсвийн нийт зарлагын 14.6 болон 13.5 хувь боловсролын салбарт тус тус оногдож байсан юм."<sup>10</sup> Шийдвэр гаргагчдын зүгээс "зай"-наас хичээл сургалтын үйл ажиллагаа явагдаж буй тул халаалт, дулаан, үдийн хоол гэх мэт урсгал зардлыг хэмнэх боломжтой гэж үзсэн боловч "зайн сургалт"-ад бэлтгэхэд боловсролын салбар бэлэн биш бөгөөд нэмэлт төсөв, хөрөнгө оруулалт шаардлагатай болохыг олж хараагүйгээс нэгэнт бий болоод байсан сурлагын хоцрогдол, чанарын зөрүүг улам даамжруулав.<sup>11</sup>

Энэ талаар "Боловсролын салбарын төсөв санхүүжилтэд үзүүлэх Монгол Улсын нийт өрийн нөлөө" судалгааны тайланд "... боловсролын салбарын санхүүжилт одоо байгаа түвшнээс буурвал бидний өнөөгийн байдлаар хүрсэн бүх амжилт буурч, ядуурал нэмэгдэн, тэгш бус байдал улам гүнзгийрэх үндэс болно"<sup>12</sup> гэсэн дүгнэлт бодит байдал болохыг харуулсан юм. Иймд боловсролын салбарын төсвийг хуулиар хамгаалж, ямар ч хямралын үед хэмнэх, хасах улс төрийн шийдвэр гарахаас сэргийлэхгүйгээр тэгш байдал, чанартай боловсрол олгох, хэнийг ч үл орхих зэрэг зорилго, зарчмууд тунхаг төдий байсаар байх юм.

## 2. Боловсролын салбарт хэрэгжсэн "зайн буюу цахим сургалт"-ын бодлогууд цар тахлын үед дэмжлэг үзүүлж чадсангүй.



2021 оны 4 дүгээр сар. Зайнаас хичээллээд хагас жил болсон сурагч (Зургийг Б.Тамир)

Манай улсын хувьд зайн сургалтыг 2000 оны эхэн үеэс хөгжүүлж, 2002 оноос "Зайн сургалтын үндэсний хөтөлбөр," 2005-2012 оны хооронд хэрэгжүүлсэн "Цахим Монгол үндэсний хөтөлбөр," 2012-2016 оны хооронд "Нэг Монгол санаачилга" зэрэг хөтөлбөрүүд хэрэгжүүлсэн боловч нийтээр зайны сургалтад шилжих шийдвэр гарах үед суралцагчдын эрэлт хэрэгцээг

10 "Бүх нийт боловсролын төлөө!" Иргэний нийгмийн үндэсний эвсэл, "Боловсролын салбарын төсөв санхүүжилтэд үзүүлэх Монгол Улсын нийт өрийн нөлөө," 2021 он, 15 тал.

11 "Ковид 19 боловсролын салбарт үзүүлж буй нөлөө" мониторингийн тайлан, 2021 он.

12 Мөн тэнд, 9 тал.



орчин үеийн түвшинд хангахуйц хууль эрх зүйн орчныг ч, хэрэгжүүлэх системийг ч цогцоор нь бий болгож хараахан чадаагүй, бүх шатны боловсролын байгууллагууд 100 хувь зайн сургалтад шилжин ажиллахад бэлэн бус байсан гэж мэргэжилтнүүд үзэж байна.<sup>13</sup> Тодруулбал, “КОВИД 19-ийн шалтгаант хөл хорионы үеийн багшлахуй, суралцахуй” тайланд дурдсанаар “зайн сургалтанд шилжихэд багш нарыг техник хэрэгсэл, арга зүй, удирдамжаар хангаагүйгээс багш нар өөрсдийн зардлаар тоног төхөөрөмж авахад хүрсэн бөгөөд хэрхэн зайн сургалт явуулах талаар мэдлэг, туршлага бүрдээгүй байсан” гэсэн нь боловсролын тогтолцоонд өмнө хэрэгжсэн бодлого, хөтөлбөрүүд тунхаг төдий байсны нотолгоо болов. Мөн зайн сургалтын агуулга, арга зүйг бэлдээгүй байсныг теле хичээлийг шинээр бэлдэж, нэвтрүүлсэн дараах үзүүлэлтээс тодорхой харж болно.

БШУЯ-наас сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн хөтөлбөрийг 2020 оны 2-р сарын 3-ны өдрөөс эхлэн хичээлийн жил дуустал теле хичээлээр зохион байгуулсан явуулсан. Энэ хугацаанд нийт **4485 теле хичээлийг** бэлтгэж, орон даяар цацагддаг 16 телевизийн сувгаар дамжуулан суралцагчдад хүргэжээ.<sup>14</sup> 2020 оны 2-5-р сарын 30-ны өдрийг хүртэл цацагдах хичээлүүдийг Монголын Телевизийн холбооны гишүүн 15 телевиз хуваарийн дагуу бичиж, олон нийтэд түгээсэн бол 5-р сарын 25-29-ний өдрүүдэд нэмэлтээр бичигдсэн 1, 2 дугаар улирлын Теле хичээл бичлэг хийх ажилд дээрх 15 телевиз дээр VTV телевиз нэмэгдэж, нийт 16 телевиз оролцсон байна. Эдгээр хичээлийг онлайн хэлбэрээр [econtent.edu.mn](https://econtent.edu.mn)<sup>15</sup> сайтад байршуулснаар сурагчдыг хүссэн үедээ нөхөж болон давтан үзэх боломжоор хангажээ.

2021 оны хичээлийн жилд хөл хорио дахин сунгагдаж, хичээлийг теле болон цахимаар үргэлжлүүлсэн бөгөөд өмнөх үр дүнд нэмэлт, сайжруулалт хийж, сургалтын үйл ажиллагааг түр зогсоосон нийт хугацаанд **5284 теле хичээл** бэлтгэн дохионы хэлний орчуулгатайгаар, 104 интерактив хичээл, 2775 цахим хичээл, 50 цахим контент, 30 радио болон аудио хичээл бэлтгэн [econtent](https://econtent.edu.mn), бусад цахим хуудсаар хүргэсэн.<sup>16</sup>

Мөн Боловсролын тухай хуульд зайны сургалтад нийтээр шилжих тухай зохицуулалт байхгүй, 2020 оны боловсролын төсөвт зайн сургалттай холбоотой ямар нэгэн төсөв төлөвлөгдөөгүй байсан тул тухай бүрд холбогдох эрх бүхий байгууллагаас шийдвэр гаргаж, батлагдсан төсөвтөө зохицуулалт хийж шийдвэрлэх чиглэлийг Засгийн газраас авч ажилласан байна.

13 “Боловсрол: Чанар, Санхүүжилт, Хариуцлага” иргэний нийгмийн үндэсний Х чуулганы “Ковид 19 ба Боловсрол” байр суурийн баримт бичиг, 2020 оны 12 сарын 9-ний өдөр

14 “Онцгой байдлын үеийн теле хичээлийн үр дүн, түүний тохиромжтой байдал”, 2020, 6 дахь тал.

15 <https://econtent.edu.mn/>

16 “БШУС-ын 2021 оны 5 сарын 21-ны өдрийн А/190 дүгээр тушаалын хавсралт”

### 3. Боловсролын гадна үлдэж буй бүлгүүдэд боловсролын тогтолцоо хариу үйлдэл үзүүлж чадаагүй бөгөөд үүний улмаас сургалтын хоцрогдол гүнзгийрэв.

БШУЯ-ны мэдээгээр гэр бүлийн орчинд нь дэд бүтэц, интернэт, гэрэл цахилгаан, техникийн боломж нөхцөл бүрдээгүйн улмаас 330 сумын 172,300, 46 багийн 6277, нийт 178,577 суралцагч теле хичээлд хамрагдаж чадаагүй<sup>17</sup> бөгөөд Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн тайланд теле хичээлд хамрагдсан сурагчдын ирц улсын хэмжээнд дунджаар 81 хувьтай<sup>18</sup> гэж дүгнэсэн байна. Харин НҮБ-ын Хүүхдийн сангаас өнгөрсөн хагас жилийн хугацаанд дунджаар нийт сурагчдын 21 хувь нь ямар нэг шалтгаанаар теле хичээлээ огт үзээгүй гэдэг дүгнэлтийг хийжээ.



Малчин өрхийн хүүхэд ТВ хичээл үзэж буй нь  
(Эх сурвалж [www.gogo.mn](http://www.gogo.mn))

БШУЯ-наас өгсөн мэдээгээр теле хичээлд хамрагдалтын хувьд эхний 2 сард 81 хувьтай байсан бол дараагийн сараас 66 хувь болон буурсан үзүүлэлттэй гарчээ.<sup>19</sup> Энэ нь тухайн хичээлийн жилд улсын шалгалтгүйгээр анги дэвшүүлэн суралцуулах болон цаашид танхимаар хичээллэхгүйгээр зуны амралтыг эхлүүлэх, багш нартаа үнэлгээг

бууруулахгүйгээр дүгнэх зөвлөмж өгсөнтэй холбоотой сурагчдын хичээл хийх хандлага эрс буурсан байж болохоос гадна теле хичээл зааж байгаа багшийн хурдыг гүйцэхгүй тул ойлгохгүй байгаа тухай шүүмжлэл хамгийн олон байв.

#### Хүүхдүүдийн өнцгөөс авч үзвэл:

- багштайгаа тухай бүр холбогдож, ойлгоогүй зүйлээ асуух боломжгүй;
- хичээл хийх гэрийн нөхцөл, техник хэрэгсэл дутмаг, худалдан авах боломжгүй, олуулаа суралцдаг;
- ихэнх тохиолдолд эцэг эхийн дэмжлэг сул байдаг;
- хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн суралцах нөхцөл, арга зүй нь нэмэлт тохируулга, цаг хугацаа шаарддаг;

17 Мөн тэнд.

18 БМДИ, “Онцгой байдлын үеийн теле хичээлийн үр дүн, түүний тохиромжтой байдал,” 2020 он, 16 тал.

19 “Ковид цар тахлын боловсролд үзүүлж буй нөлөө,” 16 тал.

- хичээл хийх нөхцөл боломжтой ч охидын хувьд гэр цэвэрлэх, дүүгээ харах, хичээл хийлгэх, хөвгүүдийн хувьд гэр бүлийнхээ амьжиргааг залгуулахын тулд ажил хөдөлмөр эрхлэх, сургуулиас завсардах магадлалтай;
- малчин өрхийн хүүхдүүд мал аж ахуйн ажилд туслах, байгаль цаг уураас үүдэлтэй кабель тасалдах, нарны зайн цэнэггүй байдаг;
- үндэстний цөөнхөд зориулж бэлтгэсэн хичээлгүй тул теле хичээлийг орчуулан хүргэж байсан ч бүх хичээлийг хүргээгүй зэрэг боломжоор бүрэн хангагдаж чадаагүй нөхцөлд суралцаж буйг шийдвэр гаргалтанд харгалзан үзэж чадаагүй юм.<sup>20</sup>

#### **4. Багш нарт үзүүлэх дэмжлэг бага ч, салбарын ачааг үүрэх хариуцлага өндөр байв.**

Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын хувьд сургалтын үйл ажиллагааг хэвийн зохион байгуулахад гар утас, компьютер, интернэтийн орчин дутмаг, олонх нь зайны сургалтаар хичээл зааж үзээгүй, сургалтад хамрагдаж байгаагүй, цахим орчны программ хангалтай ашиглаж мэдэхгүй, цахим хичээлийг удирдан явуулах бэлтгэл багатай, багшлахыг гэрийн ажилтайгаа хослуулах зэрэг аливаа төрлийн дэмжлэг, тусламжаас ангид ганцаарчлан бодит байдалтай нүүр тулжээ. “КОВИД-19”-ийн шалтгаант зайны сургалтад багш нар бэлэн байсан эсэхийг дөрвөн үзүүлэлтээр асуухад оролцогчдын 73.3 хувь нь өмнө нь зайны сургалтаар “хичээл зааж байгаагүй”, 75.2 хувь нь ийм төрлийн “сургалтад хамрагдаж байгаагүй,” 20 хувь нь цахим хэрэгсэл “ашиглаж мэдэхгүй”, 2.8 хувь нь цахим орчны программ хангалтай “ашиглаж мэдэхгүй” байдалтайгаар зайны сургалт эхлүүлжээ.<sup>21</sup>

Мөн сургалтыг теле хичээлээр явагдаж байгаа хэмээн тооцож, багш нарын зайнаас ажиллах үеийн ажлын ачааллыг тооцолгүйгээр ажлын үнэлгээний аргачлалдаа өөрчлөлт оруулж, уян хатан хандалгүйгээр цалин хөлсний зардлаас хэмнэлт гаргав. Гэтэл багшийн ажлын ачааллыг зөвхөн сурагчидтай эргэх холбоо тогтоон ажиллах байдлаар тооцвол нийслэлд 1 анги дунджаар 45 сурагчтайгаар 8-20 бүлэгт ордог тул 7 хоногт дунджаар 360-900 сурагчийг хянах, харилцах шаардлага багш нарт тулгарсан. Энэ нь өдөрт 72-180 сурагчтай холбогдоно гэсэн үг бөгөөд хамгийн олон суралцагчтай

20 Ялангуяа, зайн сургалтын эхний жилд суралцагчдын олонлог, ялгаатай байдлыг олж харж чадаагүйгээс хариу арга хэмжээ авах хугацааг хожимдуулсан боловч БШУЯ-ны зүгээс багш нарт дата олгох, хэвлэмэл материал тараах, цахим сан үүсгэх, интернэтгүй нөхцөлд ч ашиглаж болох аппликейшн бүтээх зэрэг арга хэмжээнүүд авч эхэлсэн сайн талтайн Хэдий тийм боловч “цар тахал” эхлэх үед салбарын бодлого, төлөвлөгөөгүй ажилласныг иргэний нийгмийн зүгээс цохон тэмдэглэж, тухай бүр санал зөвлөмжийг хүргүүлж байсан юм.

21 “Ковид 19 шалтгаант хөл хорионы үеийн багшлахуй, суралцахуй”, 2020 он, 21 дэх тал

сургууль, багш, сурагчдын онцлогтой холбон үзвэл хөл хорионы эхэн үеийн зайны сургалтын чанарын асуудал ч эргэлзээтэйг харуулж байна.

## **5. Онцгой байдлын үед боловсролын салбарт хэрэгжүүлэх мэргэшсэн бодлого, хөтөлбөрийг баталж, тогтвортой хэрэгжүүлэх шаардлагатайг харуулав.**



2021 оны 5 дугаар сар. Сүхбаатрын талбай.  
Ангийн найзуудын уулзалт (Зургийг Б.Тамир)

Өмнө дурдсанаар улс оронд цар тахал дэгдээгүй байх үед хичээл, сургалтын биечилсэн үйл ажиллагааг сөрөг үр дагаврыг тооцолгүй, судалгаа шинжилгээнд үндэслэлгүйгээр улс төрийн шийдвэрээр зогсоов. Гэтэл дэлхийн улс орнууд хамгийн сүүлийн мөч хүртэл сургалтыг зогсоохгүй байх, зогсоосон ч аль болох богино хугацаанд авч хэрэгжүүлэх буюу дасан

зохицоход чиглэсэн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлж байв.

Манай улсын хувьд сургалтын үйл ажиллагааг аль болох биечлэн зохион байгуулахгүйгээр цар тахлын нөлөөг бууруулах бодлогыг баримталж байсан бөгөөд энэ талаарх шийдвэрийг мэргэжлийн байгууллага гэхээс илүү, бусад салбарын асуудал хариуцсан албан тушаалтнуудын шийдвэр жин дарж байв. “Ковид 19 цар тахлын боловсролын салбарт үзүүлж буй нөлөө” мониторингийн тайланд хичээл сургалтын биечилсэн үйл ажиллагаа зогссоноор “хүүхэд гэртээ хараа хяналтгүй үлдэх, хүүхэд асрах, харах үйлчилгээ байхгүй, гэртээ боловсролын үйлчилгээнд хамрагдах үед туслах, хяналт тавих дэмжлэггүй, гэр бүлийн таагүй орчинд олон цагаар байх, хоол хүнсний үйлчилгээнээс тасрах, дунд, ахлах ангийн хөвгүүд хөдөлмөр эрхлэх зэрэг олон асуудлууд зэрэгцэн үүссэн юм. Мөн урт хугацаагаар хилийн хориг тавих, орон нутгийн хөдөлгөөнийг хязгаарлах, зарим үйлчилгээний газруудыг хаасан зэргээс үүдэн иргэдийн орлого буурах, үүнээс үүдсэн сэтгэл зүйн хямралд өртөх, гэр бүлийн хүчирхийлэл нэмэгдэх, архи дан согтуурах явдал түгээмэл болох зэрэг хүүхдийн эрх хамгаалалд сөрөг үр дагаврууд гарсан юм.”

Дээрх бүх мэдээллийг дүгнэн үзвэл, цар тахлын үед боловсролын салбар ТХЗ-4-өөр тодорхойлсон зарчим, зорилтуудыг хэрэгжүүлэхэд анхаарах гэхээсээ, салбарын хувьд өмнө олж аваад байсан ахиц дэвшлүүдээ хэрхэн хадгалж үлдэх нь тодорхойгүй нөхцөл байдалтай нүүр тулсан юм.

## ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН 4 ДҮГЭЭР ЗОРИЛТ: МОНГОЛ УЛСЫН ХЭРЭГЖИЛТИЙН ИРГЭДИЙН ОНОО (2020-2022)

Д/д	Чиглэл	-5	-4	-3	-2	-1	0	1	2	3	4	5
		Маш их ухарсан	Их ухарсан	Дунд зэрэг ухарсан	Бага зэрэг ухарсан	Маш бага ухарсан	Ямар ч ахиц гараагүй	Маш бага ахиц гарсан	Бага зэрэг ахиц гарсан	Дунд зэрэг ахиц гарсан	Их ахиц гарсан	Маш их ахиц гарсан
1	Засаглал, бодлогын хүрээ											
2	Үндэсний хөгжлийн төлөвлөгөө, стратеги, төсөв											
3	Тодорхой бүрэн эрх бүхий байгууллагууд											
4	Үндэсний түвшин дэх хэрэгжилт											
5	Орон нутгийн түвшин дэх хэрэгжилт											
6	Олон нийтийн мэдлэг, чадавхийг хөгжүүлэх											
7	Хяналтын механизм											
8	Ил тод байдал ба харууллага											
9	Олон талын түншлэл											
10	Иргэний нийгмийн оролцоо											
<b>Нэмэлт (cross-cutting) салбар хоорондын асуудлуудын хүрээ:</b>												
А.	Сүүлийн ҮСДИ-ээс хойш гарсан дэвшил											
Б.	Хэнийг ч үл орхих											

## ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН 4 ДҮГЭЭР ЗОРИЛГЫН ХЭРЭГЖИЛТ ИРГЭДИЙН ОНООНЫ ҮНЭЛГЭЭ

### 1. Засаглал болон бодлогын хүрээ

Монгол Улсын Засгийн газраас хамгийн сүүлд буюу 2019 онд ТХЗ-ын хэрэгжилтийн үндэсний сайн дурын илтгэлийг албан ёсоор илгээсэн.<sup>22</sup> Уг тайлангийн ТХЗ-4-ийн хэрэгжилттэй холбоотой хэсгийг үзвэл зөвхөн бичиг үсэг тайлагдалт, сургууль завсардалт, боловсролын чанар, хүртээмж хот, хөдөөд ялгаатай байгаа асуудлыг цөөн тооны албан ёсны статистик мэдээллээр харуулсан тойм тайлан илгээжээ.

Улсын Их Хурал (УИХ)-аас ТХЗ-ын хэрэгжилтийг хурдасгахад Засгийн газарт дэмжлэг үзүүлэхийг зорьж, Тогтвортой хөгжлийн дэд хороог 2022 онд байгуулсан нь ахиц дэвшил болжээ. Тус хороо нь УИХ-ын 7 гишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд даргаар УИХ-ын гишүүн Х.Булгантуяа ажиллаж байна.

УИХ-ын албан ёсны эх сурвалжаас үзвэл тус хорооны хурал 2022 оны 5-р сараас хойш зохион байгуулагдаагүй бөгөөд дэргэдээ Тогтвортой Хөгжлийн олон талт зөвлөлийг байгуулж,<sup>23</sup> тус зөвлөлийн үйл ажиллагааг НҮБ-аас дэмжин ажиллахаа албан ёсоор мэдэгдэж, зөвлөлийн гишүүн болсон байна.<sup>24</sup> Энэхүү зөвлөлийн анхдугаар хурлын тэмдэглэлд тусгагдсан гишүүдийн жагсаалтаас үзвэл Монгол Улсад ажиллаж буй олон улсын донор байгууллагууд, холбогдох төрийн байгууллага, хувийн хэвшлийн төлөөллүүд орсон байна. Гэвч ТХЗ-ын хэрэгжилтэд тогтмол хяналт тавин ажиллаж буй хүний эрх, үндэсний иргэний нийгмийн байгууллага, үйлдвэрчний эвлэл зэрэг томоохон нэгдлийн төлөөлөл ороогүй байна.

ТХЗ 4-ийн хувьд БШУЯ-нд хариуцсан ажилтан өнөөг хүртэл томилогдоогүй, жил тутам хийдэг ТХЗ 4 зорилгын хэрэгжилтээр зохион байгуулдаг олон талын оролцоот Үндэсний зөвлөгөөн сүүлийн жилүүдэд хийгдээгүй.

### 2. Үндэсний хөгжлийн төлөвлөгөө, стратеги, төсөв

Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийг үнэлсэн “Иргэний нийгмийн тодруулагч тайлан”<sup>25</sup>-г 2019 онд бичих үед “Тогтвортой хөгжлийн

22 <https://www.undp.org/mongolia/publications/mongolia-voluntary-national-review-report-2019>

23 <https://www.parliament.mn/nn/17530/>

24 <https://mongolia.un.org/index.php/mn/175675-togtvortoy-khogzhliyn-olon-talt-zovlol-bayguulagdlaa>

25 “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл, Иргэний нийгмийн тодруулагч тайлан “Тогтвортой хөгжлийн 4-р зорилгын хэрэгжилт,” (Улаанбаатар хот, 2019 он)



үзэл баримтлал-2030” бодлогын баримт бичгийг Монгол Улсад хэрэгжиж байв. Гэвч 2020 оны 5-р сарын 13-ны өдөр “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг УИХ-аас баталснаар 2050 он хүртэл 30 жилийн хугацаанд хөгжлийн шинэ бодлогын баримт бичиг хэрэгжиж эхлэв. Ингэснээр ТХЗ-2030 оноос цааш ч хэрэгжих үндэсний алсын хараа бий болсон нь давуу талтай болсон байна.

Энэхүү “Алсын хараа-2050”-ийг бодлогын гол чиглэлээ болгосон улс төрийн хүчин УИХ-ын 2020 оны сонгуульд ялалт байгуулснаар 2020-2024 оны Засгийн газар тус баримт бичгийн хэрэгжилтийг бүхэлд нь хангахад зорин ажиллах боломжтой болсон. Уг баримт бичгийн хоёрдугаар бүлгийг “Хүний хөгжил” хэмээн томъёолж, 2.1-р зорилтыг “Боловсрол” гэж тодорхойлсон байна.

Тус баримт бичгийн ерөнхий зорилтыг Тогтвортой хөгжлийн 4-р зорилго, “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-тай харьцуулан үзвэл зарим талаар өмнөх Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалаас илүү ТХЗ-4 дүгээр зорилготой агуулгын хувьд уялдаж буйг хүснэгт 1-ээс харж болно. Мөн үндэсний аль аль бодлого нь ТХЗ-4 дэх “насан туршдаа суралцах” боломжтой боловсролын тогтолцоог бий болгох хэмээн тодорхойлж байсан нь манай улсын хувьд нэн тэргүүлэх ач холбогдолтой асуудал болох аж.

Хүснэгт 1: Хөгжлийн баримт бичгүүдийн зорилго

Тогтвортой хөгжлийн 4-р зорилго	“Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын Нийгмийн тогтвортой хөгжлийг хангах 2.2-р зорилт	“Алсын хараа-2050” хөгжлийн бодлогын 2.1-р зорилт
<p><b>Бүх хүн тэгш хамруулсан, тэгш байдлыг хангасан, чанартай боловсрол эзэмших явдлыг баталгаажуулах ба бүх хүн насан туршдаа суралцах</b> боломжийг хөхиүлэн дэмжинэ (албан бус орчуулга)</p>	<p>2.2 “...иргэн бүрт хүртээмжтэй, чанартай боловсрол олгох, <b>насан туршийн</b> боловсролын үндэсний тогтолцоог бүрдүүлэх...” Нийгмийн тогтвортой хөгжлийг хангах зарчим: Иргэний болон насан туршийн боловсролын тогтолцоо нь нээлттэй, хүртээмжтэй, чанартай байх;</p>	<p>“<b>Хүн бүрд</b> чанартай боловсрол эзэмших <b>тэгш боломж</b> бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн <b>амьдралын баталгаа</b>, улс орны хөгжлийн суурь болгон <b>насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ</b>”</p>

“Алсын хараа-2050” хөгжлийн баримт бичгийн хувьд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2021-2030 оноор авч үзэж, хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтийг 2025, 2030, 2050 онуудаар тодорхойлон баталжээ. Ийнхүү энэ чиглэлээр нийт 43 үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжилтийг 20 шалгуур үзүүлэлтээр хэмжих харьцангуй дэвшилтэт, тодорхой үйл ажиллагаанууд тусахад “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн зүгээс идэвхтэй оролцож, гурван ч удаа саналаа бичгээр хүргүүлж байсан юм.

Хэдий тийм боловч “Алсын хараа-2050”-д заасан боловсролын зорилтуудыг ТХЗ-4 -ийн дэд зорилтуудтай харьцуулж авч үзвэл 4.6 дугаар зорилго болох “Бичиг үсэг тайлагдалт”-тай холбоотой зорилго үндэсний стратегид тусаагүй сул талтайг харж болно (*Хавсралт 1*). Энэ нь Хүн амын тооллогоор бичиг үсэг тайлагдалтын түвшингийн үзүүлэлт 98 хувиас дээш гардагтай холбоотой боловч “боловсролын чанар”-ын үзүүлэлт хангалтгүй байгаа тул цаашид бичиг үсэг тайлагдаагүй иргэд бодлогын гадна үлдэх эрсдэлтэйг харуулж байна. Тодруулбал, “Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаа (ОУБТС/MICS)-ны дүнгээс харахад 2/3-р ангийн хүүхдүүдийн дөнгөж 44.4 хувь нь унших чадварын доод түвшинг, 33.6 хувь нь тоо бодох чадварын доод түвшинг эзэмшиж байна”<sup>26</sup> гэж НҮБ-ын баримт бичигт дурджээ. Мөн ТХЗ-4.7 дахь зорилт болох “дэлхийн иргэний боловсрол”-ыг хэрэгжүүлэхтэй уялдсан зорилт хөгжлийн бодлого 2050-д бүрэн утга, агуулгаар тусгагдаагүй сул талыг Хавсралт-1-ээс харж болно.

2030 онд хүрэх тогтвортой хөгжлийн зорилгод хамгийн хол байгаа үзүүлэлт нь багш нарыг тэтгэлэгт хамруулах (4.b.1), насанд хүрсэн хүм амд мэдээлэл харилцаа холбооны ур чадвар эзэмшүүлэх (4.5.1), бүх шатны сургалтын жендэрийн тэгш байдлыг хангах (4.4.1) шалгуур байна<sup>27</sup>.


Боловсрол, шинжлэх ухааны яамны зүгээс 2021-2030 онд хэрэгжүүлэх “Боловсролын салбарын дунд хугацааны төлөвлөгөө”-г 2020 онд баталж,<sup>28</sup> “Монгол Улсын иргэний хөгжлийн хэрэгцээг хангахуйц чанартай, нээлтэй, тэгш хүртээмжтэй, уян хатан боловсролын үйлчилгээнд тулгуурлан мэдлэгт суурилсан нийгэм болон дижитал технологийн эринд ажиллаж амьдрах нийгмийн идэвхтэй оролцоо бүхий, тасралтгүй хөгжих чадамжтай иргэнийг цогцоор нь хөгжүүлэх” зорилгыг дэвшүүлсэн байна. Мөн уг баримт бичигт тэргүүлэх чиглэлийн 15 зорилт, 47 хөтөлбөр, 254 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 2021-2025 онд нийт 16,405.8 тэрбум төгрөгийн санхүүжилт боловсролын салбарт шаардлагатай байгааг тооцоолжээ. Тодруулбал, ДНБ-ий 4.7-5.4 хувь, улсын нэгдсэн төсвийн зарлагын 15.4-17.3 хувийг эзлэх шаардлагатай байгааг урьдчилан тооцож байсан ч бодит байдал дээр 2021 онд боловсролын салбарын зарлага улсын төсвийн зарлагад эзлэх хувь 3.5 хүртэл буурч, энэ нь боловсролын салбарт тохиолдоогүй ноцтой үзүүлэлт болохыг доорх 20 жилийн графикаас харж болно.

26 “Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ 2023-2027 он” Монгол Улс, 2022 оны 5 дугаар сар, 9-р тал.

27 НҮБХХ, Боловсролын салбарын төсвийн зарлагын шинжилгээ: хандлага болон өнөөгийн нөхцөл байдал, 2021 он

28 Боловсрол, шинжлэх ухааны яам, [www.meds.gov.mn](http://www.meds.gov.mn)



График 1: Улсын нэгдсэн төсвийн зарлагад боловсролын салбарын эзлэх хувь<sup>29</sup>

Энэ талаар “Бүх нийт боловсролын төлөө!” иргэний нийгмийн үндэсний эвслийн зүгээс “Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хууль батлагдсанаар боловсролын сайдын төсвийн багцаас өөр сайдын багц руу шилжүүлэн зарах эрх зүйн үндэслэл тавигдсан нь эрсдэлт хүчин зүйл мөн<sup>30</sup> болохыг сануулж байсан. Ийнхүү Ковид-19 цар тахлын шалтгаантайгаар “цэцэрлэг, сургуулийн хичээл, сургалтын үйл ажиллагааг бүрэн зогсоох болсонтой холбогдуулан гэрэл цахилгаан, цэвэр, бохир ус, түлш халаалт, багш нарын зарим шагнал, урамшуулал гэх мэт боловсролын салбарын 1,6 тэрбум орчим төсвийг өөр салбарт зарцуулсан” байна. Үүнийг Хүснэгт-2 дахь дэлгэрэнгүй мэдээллээс харах боломжтой юм.

НҮБХХ-өөс Боловсролын салбарын төсвийн зарлагын шинжилгээг 2021 онд хийлгэсэн бөгөөд 2012-2019 оны хоорондох 7 жилийн зарлагын хандлагаар боловсролын салбар нь Засгийн газрын нэн тэргүүнд анхаарах салбарын тоонд багтдаг гэж дүгнэх боломжгүй, симуляци хийж үзэхэд Алсын хараа 2050-ын ХХИ-дэх боловсролын индексийг 2025 онд 0.77, 2030 онд 0.85-д хүргэх зорилт боловсролын салбарын ахиц, дэвшлийн өнөөгийн

29 Эх сурвалж: [www.1212.mn](http://www.1212.mn); Бодлогод залуусын хяналт ТББ-ын цахим хуудсаас үзэж, дэлгэрэнгүй тоон мэдээлэл авах боломжтой: <https://www.policywatch.mn/educationbudgetdata.html>

30 “Ковид 19 боловсролын салбарт үзүүлж буй нөлөө” мониторингийн тайлан, 74 тал.

хурдаар биелэх боломжгүй байна<sup>31</sup> гэж үзжээ.

ЕБ-ын 2015-2019 оны төсвийн зарлагын гүйцэтгэлд хийсэн дүн шинжилгээгээр боловсролын санхүүжилтийн тэгш байдлын зарчим алдагдсан байна гэж үзэж, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн өнөөгийн алдаа, хэт их хоцрогдлоос үүдэлтэйгээр эрэлт аль хэдийнээ хуримтлагдсан байгааг илрүүлжээ.

---

31 НҮБХХ, Боловсролын салбарын төсвийн зарлагын шинжилгээ: хандлага болон өнөөгийн нөхцөл байдал, 2021 он

## Хүснэгт 2: Боловсролын салбарын төсвийн зарим үзүүлэлтийн харьцуулалт

Боловсрол, шинжлэх ухааны сайдын багц	2020 он			2021 он			2022 он			2023 он				
	Батлагдсан улсын төсөв <sup>32</sup> (сая төгрөгөөр)	Боловсролын зардал (сая төгрөгөөр)	Улсын нэгдсэн зардалд эзлэх хувь	Батлагдсан улсын төсөв <sup>33</sup> (сая төгрөгөөр)	Боловсролын зардал (сая төгрөгөөр)	Улсын нэгдсэн зардалд эзлэх хувь	Салбарын дунд хугацааны зорилт (шаардлагатай төсөв, тэрбумаар)	Салбарын дунд хугацааны зорилт (улсын төсөвт эзлэх хувь)	Батлагдсан улсын төсөв <sup>34</sup> (сая төгрөгөөр)	Салбарын дунд хугацааны зорилт (шаардлагатай төсөв, тэрбумаар)	Салбарын дунд хугацааны зорилт (улсын төсөвт эзлэх хувь)	Салбарын дунд хугацааны зорилт (улсын төсөвт эзлэх хувь)		
<b>Нийт төсөв</b>	<b>1,717,062.1</b>	<b>1,644,245</b>	<b>11.8%</b>	<b>1,707,825.0</b>	<b>539,380</b>	<b>3.5%</b>	<b>2,997.9</b>	<b>15.4%</b>	<b>2,321,249.2</b>	<b>2,940.9</b>	<b>15.9%</b>	<b>2,687,402.4</b>	<b>3,218.3</b>	<b>16.4%</b>
Урсгал зардал	1,393,612.9			1,345,993.6					1,964,275.3			2,158,121.0		
Үүнээс: Сургуулийн өмнөх боловсролын тусгай зориулалтын шилжүүлэг	449,557.7			406,692.0										
Ерөнхий боловсролын тусгай зориулалтын шилжүүлэг	780,922.8													
Хөрөнгийн зардал	323,449.2			361,831.5					356,973.8			529,281.5		

Тусгай зориулалтын шилжүүлэг буюу сургууль, цэцэрлэгийн төслийг орон нутаг руу шилжүүлэхгүйгээр БСШЯ-аас шууд сургууль, цэцэрлэг рүү шилжүүлдэг, төвлөрсөн тогтолцоонд шилжсэн.

32 Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хууль, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=14829>

33 Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=15726>

34 Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16381595772311>

35 Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16532001935011>

### 3. Институцийн дэмжлэг–Тодорхой эрх үүрэг бүхий төрийн байгууллагууд

Засгийн газрын 2021 оны 12-р сарын 31-ний өдрийн “Засгийн газрын агентлаг байгуулах тухай 403 тоот тогтоол”-оор<sup>36</sup> БШУС-ын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Боловсролын ерөнхий газрыг байгуулж, Багшийн мэргэжил дээшлүүлэх институцийг татан буулгаж, орон тоог нь 171 хүртэл хүний бүрэлдэхүүнтэй ажиллахаар тогтоосон. Мөн уг тогтоолоор БШУЯ-ны харьяа Боловсролын хүрээлэн, Боловсролын үнэлгээний төвийн зарим чиг үүрэг тус агентлагт шилжсэн байна. Тус газар нь сургуулийн өмнөх, бага, дунд болон мэргэжлийн, техникийн боловсролын төсвийн ерөнхийлөн захирагч<sup>37</sup> болсноор эдгээр салбарын бодлогын уялдаа холбоог хангах, сургалтын чанар, багш нарын хөгжил, үнэлгээ зэрэг асуудлыг өргөн хүрээнд хариуцах томоохон бүтцийг бий болгожээ.

Энэхүү хэрэгжүүлэгч агентлагийн бүтцэд “Суралцагчийн хөгжлийн газар” байгуулагдсан нь хүүхдийн хөгжил, боловсролыг цогцоор харах хандлага, бодлогын шинэчлэлийг хэрэгжүүлнэ гэсэн хүлээлт иргэний нийгмийн байгууллагуудад бий болоод байна. Ялангуяа, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудлыг салбар дунд шийдвэрлэх эхлэл, бага насны хүүхдийн хөгжил халамжийг салбар дунд шийдвэрлэх эрх зүйн шинэчлэлийн суурь тавигдсанаар ТХЗ-4 хэрэгжихэд тодорхой ахиц дэвшил болно гэсэн хүлээлттэй байна. Мөн насан туршдаа суралцахуйн тогтолцоо ч засаглалын босоо (үндэсний ба орон нутгийн) болон хэвтээ чиглэлд (олон салбар дундын) нэгдмэл байдлаа хамтран ажиллахыг шаардаж байна. Боловсролын ерөнхий хуулийн төсөлд засаглал, зохион байгуулалтын асуудлууд туссан байгаа нь сайшаалтай.

Мөн 1997 оноос Боловсролын хүрээлэн нэрээр ажиллаж байсан бүтцийг 2022 онд шинэчлэн Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн болгон өөрчлөн зохион байгуулснаар салбарын судалгаа шинжилгээ, хөтөлбөрийн шинэчлэл, тогтвортой байдал шинэ түвшинд хүрэх найдлага тавьж байна.

### 4. Үндэсний түвшинд бодлого, төлөвлөгөө, стратеги хэрэгжүүлэх нь

Энэхүү ТХЗ-4 тодруулагч тайлангийн хамран буй хугацаанд цар тахлын үеийн “зайн сургалт” явуулсан цаг үе болон цар тахлын дараах нөхцөл байдлыг сэргээх шилжилтийн цаг хугацаатай давхцаж байна. Өмнөх хэсэг дурдаж байснаар энэ хугацаанд боловсролын чанар, үйлчилгээний хүртээмж төдийлөн хангалттай байж чадаагүй боловч сурлагын хоцрогдлыг арилгах цогц төлөвлөгөөг 2021-2023 онд хэрэгжүүлэхээр БСШУЯ-наас

36 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16389919713281>

37 <https://www.meds.gov.mn/post/116735>

ажиллаж байна. Ингэснээр “чанартай” боловсролын зорилтыг хэрэгжүүлэхэд тодорхой ахиц дэвшил гарах хүлээлт үүсч буй боловч PISA-гийн шалгалтын үр дүн гарсны дараа хөтөлбөрийн шинэчлэлийг хийж, сургалтын чанарыг хэрхэн сайжруулах талаар бодлого иж бүрнээр дэвшигдэх байх гэсэн хүлээлт байна.

Мөн “тэгш хамруулах” зарчим бүрэн хэрэгжиж эхлэх буюу хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид хамран сургах тойргийнхоо сургуульд суралцах цаг үед “цар тахал” дэгдсэн учир энэ заалт бүрэн утгаар хэрэгжиж, үр дүнгээ харуулах боломжийг хойшлуулсан юм. Хэдий тийм ч “тэгш хамруулах” зарчим бодлого тодорхойлогчдод хүний эрхийн зарчмын хувьд харьцангуй хүлээн зөвшөөрөгдсөн болохыг Боловсролын тухай ерөнхий хуулийн төсөлд туссан зохицуулалт, үзэл санаануудаас харж болно.

*Хүснэгт 3: ТХЗ-4 хэрэгжилтийн тойм*

<p>Зорилт 4.1.2030 он гэхэд бүх эрэгтэй, эмэгтэй хүүхдүүд үнэ төлбөргүй, эрх тэгш, чанартай бага болон дунд боловсролыг эзэмшиж, холбогдох суралцахуйн үр дүнд хүрсэн байх</p>	<p>Боловсролын тухай хуулийн шинэчлэлээр бүх нийтийн, үнэ төлбөргүй боловсролыг “суурь боловсрол” байх тухай ойлголтоос давж, Үндсэн хуулийн дагуу 12 жилийн ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй олгох тухай үзэл санаанд нийцүүлэх ахиц дэвшил гарч байна.</p> <p>БШУЯ болон харьяа байгууллагуудаас “боловсролын чанарыг дээшлүүлэх” үнэлгээ, судалгаа, шинжилгээг хэрэгжүүлж байгаа бөгөөд боловсролын салбарт статистик мэдээллийг ашиглах, цахим технологи нэвтрүүлэх зэрэг бодлогын үндэслэл, баримт нотолгоонуудыг бүрдүүлж байна.</p> <p>Боловсролын салбарын статистик үзүүлэлтээс харахад бага, дунд боловсрол олгож буй байдалд анхаарал татсан асуудлууд төдийлөн ажиглагдахгүй байна. Хэдий тийм боловч дүйцсэн хөтөлбөрөөр суралцаж буй хүүхэд залуусын тоо 2019-2020 онд 6179 байснаа 2022-2023 онд 4981 болон 1000 гаруйгаар буурсан нь боловсролын гадна үлдэж буй хүүхэд, залуус нэмэгдэж байх вий гэдэгт анхаарах шаардлагатайг харуулж байна.</p> <p>Мөн иргэний нийгмийн байгууллагын зүгээс салбарын яамнаас хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөрүүдэд саналаа хүргүүлэх, хэрэгжилтийн явцад нь хяналт шинжилгээ хийж, санал зөвлөмж хүргүүлэх байдлаар идэвхтэй оролцож байна.</p> <p>Суралцахуйн үр дүн маш доогуур байгаад иргэд, ИНБ-ууд санаа зовж байна.</p>
--	--

<p>Зорилт 4.2 2030 он гэхэд бүх эрэгтэй, эмэгтэй хүүхдүүдийг бага боловсролд бэлтгэж, бага насны хүүхдүүдийг хөгжүүлэх чанартай үйлчилгээ, тусламж, сургуулийн өмнөх боловсрол хүртээмжтэй байх</p>	<p>2022-2023 оны хичээлийн жилд СӨБ-д хамран сургалтыг нэмэгдүүлэхэд Засгийн газраас шийдэмгий арга хэмжээг авч хэрэгжүүлэв. Үүний үр дүнд цэцэрлэгийн сугалаа гэсэн ойлголтыг халж, хүсэлтээ өгсөн хүүхэд бүрийг СӨБ-д хамруулж байгааг БШУЯ-аас мэдээлж байна.</p> <p>Ялангуяа, цэцэрлэгийн хүртээмж багатай нийслэлийн хувьд хувийн хэвшлийн байгууллагуудыг татан оролцуулах, цэцэрлэгийн барилгыг шинээр барих буюу худалдан авах зэрэг урьд өмнө хэрэглэгдэж байгаагүй арга замуудыг ашиглаж байна. Улаанбаатар хотын хэмжээнд 2022-2023 онд 2-5 настай 124 мянган хүүхдийг цэцэрлэгт хамруулснаас төрийн өмчийн цэцэрлэгт 94621, хувийн өмчийн цэцэрлэгт 30 мянган хүүхэд хамрагджээ.<sup>38</sup></p> <p>Иргэний нийгмийн зүгээс дээрхийг богино хугацааны шийдэл гэж харж байгаа бөгөөд урт хугацаанд хэрэгжих шийдлээ мөн цуг авч явах нь зүйтэй гэсэн байр суурьтай байна.</p> <p>Малчдын хүүхдийг СӨБ-д хамруулах асуудал орхигдсоор байна.</p>
<p>Зорилт 4.3 2030 он гэхэд бүх эрэгтэй, эмэгтэй хүнд төлбөрийг хүчрэхүйц, чанартай техникийн, мэргэжлийн болон их сургуулийг оролцуулан дээд боловсролыг авах тэгш боломжийг бүрдүүлэх</p>	<p>2022 онд мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, УИХ-д өргөн барьснаар БШУЯ-ны харьяанд мэргэжлийн боловсролын салбар ирж, боловсролын систем бүтэн болов.<sup>39</sup> Ингэснээр улсын хэмжээнд мэргэжлийн боловсрол, сургалтын 79 байгууллага үйл ажиллагаа явуулж, 15 салбарын 185 мэргэжлээр 42 мянган залуус сурч байна.</p> <p>Дээд боловсролын салбарт хүн амын хамгийн баян чинээлэг 20% ба хамгийн ядуу 20%-ийн хоорондох дээд боловсролын хүртээмжид асар их тэгш бус байдал гарсанд санаа зовж байна.</p>
<p>Зорилт 4.4 2030 он гэхэд ажил эрхлэх, зохистой хөдөлмөр, хувийн бизнес эрхлэхтэй холбоотой техник, мэргэжлийн ур чадварыг оролцуулан бусад ур чадвартай залуучууд, насан хүрэгчдийн тоог эрс нэмэгдүүлэх</p>	<p>Яамны зүгээс сургалт-судалгаа-үйлдвэрлэлийн цогцолборыг Дархан-Уул, Орхон, Өмнөговь аймаг болон Хөшигийн хөндийг байгуулахаар төлөвлөжээ. Энэ хүрээнд Өмнөговь аймагт ШУТИС-ийн харьяа Технологийн дээд сургуулийг байгуулж, 4 мэргэжлээр 120 оюутныг элсүүлэн сургаж байна. Технологийн дээд сургуульд Улаанбаатар хотоос гадна 10 аймгаас оюутан суралцаж байна.</p> <p>Хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай ур чадвараас гадна, залуус, насанд хүрэгчид зөөлөн ур чадваруудад суралцахад анхаарах шаардлагатай байна.</p> <p>Дижитал ур чадварыг насанл хүрэгчид, маргинал бүлгийнхэнд эзэмшүүлэхэд анхаарах шаардлага байна.</p>

38 <https://montsame.mn/mn/read/307705>

39 <https://www.meds.gov.mn/post/124944>

<p>Зорилт 4.5 2030 он гэхэд боловсролын байгууллагад суралцагсдын жендерийн зохистой харьцааг хангаж, эмзэг бүлэг, түүний дотор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, нутгийн уугуул хүмүүс, эмзэг бүлгийн хүүхдүүдэд бүх шатны боловсрол, мэргэжлийн сургалтанд хамрагдах тэгш боломжийг бүрдүүлэх</p>	<p>Иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс ТХЗ-4 дэх “тэгш хамруулах” гэдгийг “зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуус” гэсэн явцуу ойлголтоор бус “хүн бүрийг боловсролд хамруулах” ялангуяа “үндэсний, хэлний цөөнх, амьжиргааны түвшнээс доогуур өрхийн, алслагдсан газар амьдарч буй, малчин өрхийн хүүхэд, залуусыг чанартай, хүртээмжтэй боловсролд тэгш хамруулах” талаар тууштай ажиллаж байна. Энэ хүрээнд “Тодорхой бүлгийн хүүхдүүдэд боловсрол эзэмшихэд тулгардаг саад тотгорууд” чанарын судалгааны тайлан (2020), “Амьжиргааны түвшин доогуур өрхийн суралцагчийг сурах боллоцоогоор хангах талаарх бодлого, түүний хэрэгжилт” (2021), “Хос хэлний боловсролын өнөөгийн нөхцөл байдал” судалгааны нэгтгэсэн тайлан (2021) зэрэг судалгаа, нөхцөл байдлын шинжилгээг явуулахад үндэсний болон хэлний цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуус, амьжиргааны түвшнээс доогуур болон малчин өрхийн хүүхдүүд чанартай боловсролыг тэгш, хүртээмжтэйгээр эзэмшиж чадахгүй байгаа нөхцөл байдал оршсоор байна.</p>
<p>Зорилт 4.6 2030 он гэхэд бүх залуус, эрэгтэй, эмэгтэй нас хүрэгчдийн дийлэнх хувийг бичиг үсэгт тайлж, тоо тооллын мэдлэгтэй болгох</p>	<p>Монгол Улс 2020 онд хүн амын тооллогыг явуулсан бөгөөд албан ёсны статистикаар бичиг үсэг тайлагдалт 98-иас дээш хувьтай байна. Хэдий тийм боловч хот, хөдөөгийн боловсролын чанарын ялгаа гүнзгийрч, “насан туршийн боловсролын тогтолцоо” бэхжиж чадахгүй байгаа, хөгжлийн бэрхшээлтэй хүн ам бүхэлдээ боловсролд хамрагдаж чадаагүй бөгөөд маргинальчлагдсан бүлгийн хүүхдүүд боловсролын тогтолцоонд бүрэн сууж чадахгүй байгаа тул энэхүү бичиг үсэг тайлагдалтын өндөр статистик эргэлзээ төрүүлэхээр байна. Мөн “Алсын хараа-2050” баримт бичгийн зорилгод бичиг үсгийн зорилго тусгагдаагүй нь цаашид бичиг үсгийн боловсролын асуудал бодлогын гадна үлдэх эрсдэлтэй байна.</p>
<p>Зорилт 4.7 2030 он гэхэд тогтвортой хөгжлийн мэдлэг, тогтвортой амьдралын хэв маяг, хүний эрх, жендерийн тэгш байдал, энх тайван болон хүч үл хэрэглэх соёлыг төлөвшүүлэх, дэлхийн иргэн байх, соёлын олон янз байдал болон тогтвортой хөгжилд соёлын оруулж буй хувь нэмрийг ойлгуулах мэдүүлэх замаар тогтвортой хөгжлийг хөхиүлэн дэмжихэд шаардлагатай мэдлэг, ур чадварыг бүх суралцагчдад олгох</p>	<p>Боловсролын багц хуулийн шинэчлэлийн хүрээнд сургалтын хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангах, агуулгын шинэчлэл хийгдэнэ гэсэн хүлээлтэй байна. Учир одоо хэрэгжиж буй сургалтын хөтөлбөр, сурах бичиг, хэрэглэгдэхүүн нь “хүний эрхэд суурилагагүй байгаа”-г салбарын экспертүүд хэдийнэ судалж, санал зөвлөмж өгсөөр байна. Ялангуяа, иргэний боловсрол гэсэн хөтөлбөрийн агуулгыг гуйвуулж, “иргэний ёс зүй” гэсэн хичээлийн дор нэг шашны боловсрол, ёс зүйн асуудлыг хэт тусгасан, “дэлхийн иргэний боловсрол”-ын агуулга огт дурдагдахгүй байгаа, зөвхөн хүрээлэн буй орчны агуулгаар “тогтвортой хөгжлийн боловсрол” хязгаарлагдаж байгаа зэрэг сул тал өдгөө хүртэл оршсоор байна. Хүний эрхэм чанар, хүний эрх, эрх чөлөө, ардчилал, тэгш байдал, хууль дээдлэх ёс зэрэг боловсролын сууринд байх ёстой эрхэмнэлүүдтэй холбох, агуулгад тусгах шаардлагатай гэж судлаачид үзэж байна.</p>

<p>Зорилт 4.a Хүүхдэд ээлтэй, хөгжлийн бэрхшээл, жендерийн мэдрэмжтэй боловсролын байгууллагыг бэхжүүлэн сайжруулж, хүн бүрийг аюулгүй, хүчирхийлэлгүй, хүртээмжтэй, үр дүнтэй суралцах орчноор хангах</p>	<p>БШУЯ-наас ариун цэврийн байгууламжийг сайжруулах санаачилга хэрэгжиж, 12 аймгийн 54 сумын 130 объектыг хүлээж авах комисс ажиллаж байнгын ашиглалтад оруулсан бол 12 сумын 49 объектод барилга байнгын ашиглалтад оруулах комисс томилуулах хүсэлтийг хүргүүлжээ. Мөн 15 аймгийн 113 суманд 280 сургууль, цэцэрлэг, дотуур байрын зураг төсөл боловсруулж, 17 аймгийн 88 сумын 200 объектын жагсаалтыг холбогдох аймгуудтай зөвшилцөх, давхардсан болон орхигдсон объект байгаа эсэх нягтлах ажил хийгдэж байгаа нь орон нутгийн хүүхэд, залуусын суралцах, амьдрах орчин нөхцөл сайжрах хүлээлтийг үүсгэж байна.</p> <p>Сургуулиуд цахим шилжилтэд бэлэн биш, интернетгүй, интернэтийн хурд хангалтгүй, компьютер болон бусад цахим хэрэглэгдхүүн туйлын хомс байна.</p> <p>УБ хотын сургуулийн барилга, хөдөө орон нутгийн дотуур байрны орчин нөхцлийн асуудал хүүхдэд ээлтэй болоход хол байна.</p> <p>Сургууль, дотуур байрны орчинд үе тэнгийн дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалт амь бөхтэй оршсоор байгаад ИНБ-ууд санаа зовж байна.</p>
<p>Зорилт 4.b 2020 он гэхэд хөгжингүй болон хөгжиж буй бусад орнуудад дээд боловсрол, түүний дотор мэргэжлийн сургалт, мэдээлэл, харилцаа холбооны технологи, техникийн, инженерийн, шинжлэх ухааны сургалтад суралцуулах зорилгоор хөгжиж буй орнуудад олгох сургалтын тэтгэлгийн тоог дэлхийн хэмжээнд нэмэгдүүлэх</p>	<p>“Боловсролын зээлийн сан”-гийн журмыг БШУЯ-аас шинэчилсэн боловч хэрэгжилт, буцаан төлөлтийн ил тод байдал, хариуцлагын асуудал хэвлэл мэдээллийн байгууллагуудын анхаарлын төвд байсаар байна. Ялангуяа, төлбөрийн боломжгүй хүүхэд, залууст тэгш боломж олгоход зориулагдаж чадахгүй байгааг, боломжтой айлын хүүхдүүдэд олгодог, зээлээ төлөхгүй олон жилийг ардаа орхиж байгаа шүүмжлэл байсаар байна.</p>
<p>Зорилт 4.c 2030 он гэхэд хөгжиж буй орнууд, ялангуяа нэн буурай хөгжилтэй болон жижиг арлын хөгжиж буй улс орнуудад багш бэлтгэх сургалтын чиглэлийн олон улсын хамтын ажиллагаагаар дамжуулан мэргэжилтэй багш нарын хангамжийг эрс нэмэгдүүлэх</p>	<p>БШУЯ-ны зүгээс “Үр дүн гүйцэтгэлд суурилсан боловсролын санхүүжилт”-ийг нэвтрүүлснээр цалин хөлс тодорхой хэмжээнд нэмэгдэж, багш нарын хөгжлийг дэмжих үйл ажиллагаа чанаржих чиглэлд салбарын яам санаачилгатай ажиллаж байна. Мөн нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын тогтоолыг шинэчилснээр ЕБС-ийн багш нар хичээл практик, өөрсдийгөө хөгжүүлэх зардлыг хувиасаа гаргадаг байдал шийдэгдэж байна.</p> <p>Багшийн хомсдол хот, хөдөөгүй бодит байдал болж, боловсролын хүртээмж, чанарыг дордуулах эрсдэл үүсгэлээ.</p> <p>Багш бэлтгэх хөтөлбөрийг чанарын өөр түвшинд гаргах шаардлагатай байна гэж ИНБ-ууд үзэж байна.</p>



## 5. Орон нутгийн түвшинд бодлого, төлөвлөгөө, стратеги хэрэгжүүлэх нь

Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийн талаар нэгдсэн мэдээлэл авах төрийн албан ёсны эх сурвалж болох <http://sdg.gov.mn/> цахим хуудаст 2022 оны 12 дугаар сарын байдлаар орон нутгийн түвшинд ТХЗ-ыг хэрхэн хэрэгжүүлж буй талаарх мэдээллийг хараахан оруулаагүй байна.

Монгол Улсад 2019 онд Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, нутгийн өөрөө удирдах ёсны асуудлыг шинэ түвшинд зохицуулах хэрэгцээ шаардлага бий болсноор 2022 оны 1-р сарын 1-ний өдрөөс “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль” хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. Уг хуулиар “боловсрол”-ын асуудалд орон нутгийн байгууллага, албан тушаалтны оролцоо, үүрэг хариуцлага “өмчийн ашиглалт, хамгаалалт”-аар хязгаарлагдсаныг Хүснэгт-3-аар харж болно. Харин сумын засаг даргын зүгээс боловсролын боловсролын байгууллагын норм, стандартын хэрэгжилтэд хяналт тавих бүрэн эрхийг олгосон байна.

*Хүснэгт 3: Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийн харьцуулалт*

2020 оны Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль (хүчин төгөлдөр) <sup>40</sup>	2006 оны Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль (хүчин төгөлдөр бус) <sup>41</sup>
20 дугаар зүйл. Орон нутгийн чиг үүрэг 20.1.18. төрийн болон орон нутгийн өмчийн <b>боловсрол</b> , эрүүл мэнд, нийгэм, соёлын <b>байгууллагын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар</b> ;	28 дугаар зүйл. Баг, хорооны Засаг даргын бүрэн эрх 28.1.5. хүн амын боловсролын түвшинг судлах, сургуулийн өмнөх насны хүүхдийг бүртгэж тухайн жилд нь сургуульд оруулах, сургууль завсардсан хүүхдийг сургалтад хамруулах арга хэмжээ авах;
59 дүгээр зүйл. Сумын Засаг даргын бүрэн эрх 59.1.20. хуульд өөрөөр заагаагүй бол нутаг дэвсгэрийн <b>боловсрол</b> , соёл, эрүүл мэнд, биеийн тамир, спортын байгууллагууд эрх бүхий байгууллагаас <b>тогтоосон стандарт, норм, нормативыг сахин мөрдөж байгаа эсэхэд тэдгээрийн харьяалал, өмчийн төрөл, хэлбэрийг харгалзахгүйгээр хяналт тавих</b> ;	29 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын нийтлэг бүрэн эрх 30.1.14. боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон аргачлалын дагуу ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг тус бүрээр нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг тогтоож мөрдүүлэх;

Хүн амын 50 гаруй хувь оршин суудаг Улаанбаатар хотын хувьд “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл”-ийг 2020 онд баталж, боловсролын салбарын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлсэн

40 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16106891904801>

41 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=343>

байна<sup>42</sup> боловч Нийслэлийн эрх зүйн байдлын тухай 2021 хуулиар<sup>43</sup> боловсролын салбартай холбоотой ямар нэг чиг үүрэг, хариуцлагыг заагаагүй нь дараах “Хөгжлийн баримт бичиг”-ийн хэрэгжилтийг хэрхэн хангах талаар тодорхойгүй нөхцөл үүсгэж байна.

Энэ нь цаашид ТХЗ-4 болон орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын үүрэг хариуцлагын уялдааг дэлгэрүүлж судлах хэрэгцээ, шаардлагыг харуулж буй бөгөөд “Боловсролын хуулийн багц шинэчлэл” явагдаж буй энэ цаг үед орон нутгийн байгууллагын чиг үүргийг тодорхой заах нь ТХЗ-4 болон “Алсын хараа-2050”-д заасан зорилго, арга хэмжээнүүд анхан шатанд хэрэгжих гол арга механизм болох юм.

#### “Нийслэлийг 2021–2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл”

##### БОЛОВСРОЛ

**Зорилт 2.1.** Ерөнхий боловсролын сургууль болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагыг мэргэжлийн багшаар бүрэн хангана.

2.1.1. Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багшлах боловсон хүчний нөөцийн судалгааг нарийвчлан гаргаж, багшийг мэргэшүүлэх, давтан сургах замаар ур чадварыг дээшлүүлсэн байна.

2.1.2. Багшийн хөгжлийг дэмжин ажлын үр дүнгээр индексийн урамшуулал олгоно.

2.1.3. Боловсролын байгууллагын өөрийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, дэмжих, багш, ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх бодлого баримтална.

**Зорилт 2.2.** Хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролд хамрагдах, бага боловсрол эзэмшихэд бэлтгэх нөхцөлөөр хангана.

2.2.1. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилга, байгууламжийг үе шаттай нэмэгдүүлэх замаар бүлэг дүүргэлтийг стандарт хэмжээнд хүргэсэн байна.

**Зорилт 2.3.** Хүүхэд бүрийг төлбөргүй, тэгш, чанартай бага болон суурь боловсрол эзэмших нөхцөлөөр хангана.

2.3.1. Ерөнхий боловсролын сургуулийн барилга, байгууламжийг үе шаттай нэмэгдүүлж, бүлэг дүүргэлтийг стандарт түвшинд хүргэсэн байна.

2.3.2. Сургууль дээрх болон хичээлээс гадуурх сургалтын үйл ажиллагааг дэмжих замаар хүүхдийн авьяас, чадварыг хөгжүүлсэн байна.

2.3.3. Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн агуулгын хүрээнд цахим хичээлийн иж бүрэн сан бүрдүүлж, зайн сургалтын үйл ажиллагааг дэмжинэ.

**Зорилт 2.4.** Боловсролын байгууллагуудыг хүүхэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ээлтэй, жендэрийн мэдрэмжтэй болгон хөгжүүлж, хүн бүрийг аюулгүй, хүртээмжтэй, үр дүнтэй суралцах орчин нөхцөлөөр хангана.

2.4.1. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын харилцан адилгүй байдал, ялгаатай хэрэгцээг тодорхойлж, сурагчдад зориулсан түгээмэл загвар, тохирох хэрэглэгдэхүүн бүхий орчин нөхцөл бүрдүүлсэн байна.

2.4.2. Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийг эрүүл баталгаат хоол, хүнсээр хангах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

2.4.3. Мэргэжлийн байгууллагатай хамтран суралцагчдыг зам тээврийн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.

42 <https://zdtg.ulaanbaatar.mn/more/32>

43 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230779072091>

## 6. Олон нийтийн мэдлэг чадавхыг хөгжүүлэх нь

ТХЗ-ын хэрэгжилтийн талаарх нэгдсэн мэдээллийн сан болох <http://sdg.gov.mn/> цахим хуудсыг Статистикийн үндэсний хорооноос ажиллуулж буй боловч мэдээлэл нь тогтмол шинэчлэгдэхгүй байна. Энэхүү тайланг бичих хугацаанд (11-12 сард) уг сайтад “Алсын хараа-2050” талаарх мэдээлэл ороогүй байв. Ялангуяа, ТХЗ-ын талаар судлах, хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгөхөд маш олон талын эх сурвалжийг хайх, судлах, тун тойм мэдээллийг авах боломжтой байгаа нь олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, оролцоог хөгжүүлэхэд томоохон бэрхшээл болж байна.

Мөн 2022 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр НҮБ болон холбогдох төрийн байгууллагууд хамтарсан “ТХЗ-Нээлтэй өдөрлөг”-ийг Сүхбаатарын талбайд зохион байгуулснаас өөр ТХЗ-ыг бүрэн цогц утгаар олон нийтэд таниулсан дорвитой арга хэмжээ хийгдээгүй байна.<sup>44</sup> Энэ өдөрлөгөөр ТХЗ-ын 17 зорилгыг бүхэлд нь нэг дор танилцуулж, энэ чиглэлээр ажиллаж буй байгууллагуудын сайн туршлагын талаарх мэдээллийг нэг дор авах боломжийг бүрдүүлснээрээ онцлог арга хэмжээ болсон.

Харин боловсролын салбарын хувьд “Тогтвортой хөгжлийн боловсрол” үндэсний хөтөлбөрийг<sup>45</sup> 2018 онд баталж байсан бөгөөд энэ хөтөлбөрийн агуулга ТХЗ-4 гэхээсээ хүрээлэн буй орчин, экологийн боловсрол олгоход чиглэсэн хөтөлбөр юм.

Иргэний нийгмийн байгууллагууд, ялангуяа “Бүх нийт боловсролын төлөө!” иргэний нийгмийн үндэсний эвслээс ТХЗ-4-ийг бүхэлд нь буюу цогц агуулгаар нь хандах, судалгаа баримт цуглуулах, бодлогын нөлөөллийг хэрэгжүүлэх, олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд анхааран ажиллаж байна. Байгууллагын зүгээс ТХЗ-4 дэх “тэгш хамруулах” гэдгийг “зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуус” гэсэн явцуу ойлголтоор бус “хүн бүрийг боловсролд хамруулах” ялангуяа “үндэсний, хэлний, амьжиргааны түвшнээс доогуур өрхийн, алслагдсан газар амьдарч буй, малчин өрхийн хүүхэд, залуусыг чанартай, хүртээмжтэй боловсролд тэгш хамруулах” талаар тууштай ажиллаж байна. Энэ хүрээнд хийгдсэн “Тодорхой бүлгийн хүүхдүүдэд боловсрол эзэмшихэд тулгардаг саад тотгорууд” чанарын судалгааны тайлан (2020), “Амьжиргааны түвшин доогуур өрхийн суралцагчийг сурах бололцоогоор хангах талаарх бодлого, түүний хэрэгжилт” (2021), “Хос хэлний боловсролын өнөөгийн нөхцөл байдал” судалгааны нэгтгэсэн тайлан (2021) зэрэг ИНБ-ууд болон бусад судалгаа, шинжилгээнд үндэслэн БШУЯ-наас “Тэгш хамран сургах боловсролын талаар баримтлах чиглэлийг 2022 онд батлан гаргасан.

44 <https://mongolia.un.org/mn/193867-togtvortoy-khogzhiyn-zorilgo-odorlog>

45 <https://www.meds.gov.mn/post/65854>

## 7. Хяналт, үнэлгээ, өгөгдөл болон тайлагнах механизм

Өмнө хэсэгт дурдсанаар ТХЗ-ын хэрэгжилтийн талаар нэгдсэн мэдээлэл авах тогтолцоо хангалтгүй байна. Ялангуяа, Засгийн газрын зүгээс 2030 гэхэд ТХЗ-ын хэрэгжилтийг дүгнэхэд ТХЗ-4 буюу боловсролын зорилго хамгийн олон үзүүлэлтээр гарах боломжтой болохыг дурдсан байна. БШУЯ-ны зүгээс боловсролын салбарын үзүүлэлтийг хүйсээр, байршлаар, хөгжлийн бэрхшээлээр ялган гаргах байдал сайжирч байгааг цохон тэмдэглэж байна.<sup>46</sup> Мөн “Алсын хараа-2050” баримт бичигтэй уялдуулан “Боловсролын хэтийн тооцоо 2020-2050”<sup>47</sup>-г гаргаж, бодлого болон статистик мэдээллийн уялдааг хангахад анхаарч байгааг талархан хүлээн авч байна. Ялангуяа, уг баримт бичиг боловсролын салбарын хөгжлийг төсөв, санхүүжилттэй нь уялдуулан харуулснаараа цаашдын хяналт, үнэлгээ, тайлагналт сайжрахад ач холбогдолтой болсон байна. 2022 онд PISA (Programme for International Student Assessment)-ийг БШУЯ-аас 196 сургуулийн 7300 орчим суралцагчдын дунд хийлгэсэн<sup>48</sup>

Гэвч ТХЗ-ийн хяналт, үнэлгээ, тайлагналтын нэгдсэн тогтолцоог хангалтгүй байгааг иргэний нийгмийн байгууллагууд анхааруулсаар байна. Тодруулбал, одоогийн бодлого, шийдвэр гаргалт мэдээллийн тогтолцоо боловсролд хамрагдаж буй эерэг үзүүлэлтүүд дээр хэт төвлөрдөгөөс тухайн үзүүлэлтийн гадна орхигдож буй цөөнх бүлгийн асуудлыг орхигдуулах хандлагатай байдаг. Жишээ дурдвал, бичиг үсэг тайлагдалт 98 гаруй хувьтай гэдэг үзүүлэлтээр бодлого хэрэгжиж байна гэсэн дүгнэлт хийхээс бус “үлдсэн 1-2 хувьд байгаа бичиг үсэггүй ямар бүлэг байна гэдгийг анхаардаггүйгээс хамгийн эмзэг, эрсдэлтэй бүлгийнхэн бодлогын гадна орхигдож болзошгүй болдог.” Энэ асуудалд иргэний нийгмийн байгууллагын зүгээс тогтмол анхааруулж, хөндлөнгийн хяналтыг тасралтгүй тавин ажиллаж байна.<sup>49</sup>

## 8. Ил тод байдал, хариуцлага, мэдээлэл авах

Монгол Улс авлигатай тэмцэх, мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлд тууштай ажиллаж байна. Жишээ дурдвал, 2022 оны 5-р сарын 1-ээс эхлэн “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хууль<sup>50</sup> хэрэгжиж эхэлснээр төрийн холбогдох байгууллагууд мэдээлэл хариуцагчийн хувьд өөрт байгаа мэдээллүүдийг нийтэд ил тод, нээлттэй өгөгдөл болгон

46 <https://www.meds.gov.mn/post/115111>

47 <https://www.meds.gov.mn/post/116609>

48 <https://news.mn/r/2534306/>

49 Тодруулбал, 2014 онд Бүх нийтийн боловсролын 6 зорилт Монгол улсад хэрхэн хэрэгжсэнд “Боловсрол дахь тэгш эрхийн асуудал” судалгааны тайлангаар хөндлөнгийн сүүдэр илтгэлийг “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн зүгээс бичиж байсан.

50 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390263044601>

нийтлэхийг үүрэг болгосон. Энэ хуулийн дагуу төрийн байгууллагууд өөрийн чиг үүргийн дагуу үзүүлж буй үйлчилгээ, төсөв санхүү гэх мэт мэдээллийг ил тод болгох ёстой боловч иргэдийн зүгээс зарим мэдээллийг хүлээн авч чадахгүй байна.

Мөн ТХЗ-4.б-гийн хэрэгжилттэй холбогдох гол механизм болох “Боловсролын зээлийн сан”-гийн дүрэм журам, хэрэгжилт, буцаан төлөлтийн ил тод байдал, хариуцлагын асуудал хэвлэл мэдээллийн байгууллагуудын анхаарлын төвд байна. Уг зээлийн сан төлбөрийн боломжгүй боловч потенциалтай хүүхэд, залууст тэгш боломж олгоход зориулагдсан боловч эцэг, эх нь төр засгийн өндөр албан тушаал хашиж байсан болон хашдаг бөгөөд топ баячуудын хүүхдүүд ч жирийн айлын хүүхдүүдийн өмнүүр орж төрөөс зээл авах, зээлээ төлөхгүй олон жилийг ардаа орхиж, энэ талаарх мэдээлэл хаалттай байсанд олон нийт, иргэдийн бухимдлыг төрүүлснээр Сангийн яам энэ талаарх мэдээллийг цахим хуудастаа байршуулав.

Авлигатай тэмцэх газрын 2022 онд хэрэгжүүлсэн “Төрийн байгууллагуудын шударга байдлын үнэлгээ”-нээс үзвэл нийт 16 яамнаас 14-т 68.4 оноогоор сүүлээсээ гуравт орсон байна. Доорх графикаас дэлгэрэнгүй мэдээллийг хүлээн авах боломжтой.

"DATA ЭРХ ЧӨЛӨӨ: ДИЖИТАЛ ХЯНАЛТ" 2022 ҮЗЭСГЭЛЭН



## ЯАМДЫН ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ, 2022



Улсын дундаж үнэлгээ [73.9]  
Шударга байдлын үнэлгээ

Шударга байдлын үнэлгээ нь 0-100 оноогоор хэмжигдэнэ. 0 нь хамгийн сур, 100 хамгийн сайн утгыг илэрхийлнэ.

Өгөгдлийн нэрсэлэлийг Тунгазүй өгөгдлийн урлагд бугаа өгөгдлийн эх үүсвэр Төрийн байгууллагын шударга байдлын үнэлгээ, Аалигатай тэмцэх газар

“Мэдээлэл авах эрхийн хэрэгжилтийн байдал хангалтгүй байна. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиас төсвийн мэдээлэл авах эрхийг хасаад шилэн дансны тухай хууль руу шилжүүлсэн гээд дээрх хуулийн дагуу төсвийн мэдээллийг авч чадахгүй байна. Шилэн дансыг жирийн иргэд ойлгож, уншиж, ашиглаж чадахгүй байна. Тийм учраас Төрийн бус байгууллагууд иргэдийг зохион байгуулалтад оруулах, төсвийн мэдээллийг уншиж чаддаг болгож байж, хяналт тавьж, авлигыг хянах нөхцөл байдал үүсээд байгааг эргэн харах шаардлагатай байна.”<sup>51</sup>

## 9. Олон талын түншлэл

Боловсролын салбарын зөвлөлдөх бүлэг (LEG), Боловсролын кластер зэрэг боловсролын оролцогч талуудтай зөвлөлдөх механизмууд зохих ёсоор ажиллаж, БСШУСЯ-наас цахим хуудсандаа үйл ажиллагааны тайлан мэдээллийг 1-7 сарын хугацаанд тавьж, Ковид-19 халдварын үеэр авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаагаа тайлагнаж, олон нийтэд нээлттэй ажилласан байна. Коронавируст халдвар (COVID-19)-ын тархалтын үед улс, орнуудын боловсролын салбарт хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх мэдээллийг хайх, орчуулах, цахим хуудаст байрлуулах ажлыг зохион байгуулсан ба тус яаманд хандан иргэд, аж ахуй нэгжээс ирүүлсэн өргөдөл гомдлыг хүлээн авах 1800-1209 дугаарын утас, 1209@mecs.gov.mn и-мэйл хаягийг шинээр байгуулан ажиллуулсан нь сайшаалтай.<sup>52</sup>

Хэдий тийм боловч зөвхөн төрийн байгууллага, олон улсын болон засгийн газар хоорондын байгууллагыг байнгын түншлэгч гэж үзэж, иргэний нийгмийн байгууллагуудтай зарим тохиолдолд хамтран ажилладаг бөгөөд бусад талууд идэвх, оролцоогүй байдаг. Мөн олон улсын байгууллагууд санхүүжилттэй төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлдэг тул, үндэсний ТББ-уудтай хамтрах харилцаа босоо тэнхлэгт буюу эрх мэдлийн тэнцвэргүй байх нь нийтлэг. Ихэнх тохиолдолд аливаа түншлэлийн механизмд зөвхөн төрийн байгууллага, олон улсын банк санхүүгийн болон ТББ-ууд, Засгийн газар хоорондын байгууллага хамтран ажилладаг. Ялангуяа, Доноруудын зөвлөлдөх механизм 2015 оноос ажиллаж байсан ба сүүлийн үед идэвхгүй байж байгаад 2021 онд дахин шинээр эхэлж байна. Мөн Орон нутгийн боловсролын бүлэг (LEG) 2019 оноос байгуулагдан ажиллаж эхэлсэн ба мандат, ажиллах зарчим, зохион байгуулалт өдгөөг хүртэл тодорхойгүй бөгөөд GPE (Global Partnership for Education)-ээс төслөө батлуулж авснаас хойш үйл ажиллагаа нь зогсонги байдалтай байна.

Төрийн зүгээс хувийн хэвшлийн байгууллагуудтай цахим шилжилтийн хүрээнд идэвхтэй ажиллах болсон боловч чанар, гарах үр дүн, тогтвортой

51 АТГ-аас 2022 онд зохион байгуулсан “Авлигын эсрэг үндэсний чуулган”-ы илтгэл, <https://iaac.mn/uploads/users/1278/files/Anti%20corruption%20B5%20inter.pdf>

52 “Ковид 19 боловсролын салбарт үзүүлж буй нөлөө” мониторингийн тайлан, 2021 он.



байдал, хүүхдийн хувийн мэдээллийн хамгаалалт, төсвийн хэт их урсгал зэрэг асуудал дээр иргэний нийгмийн байгууллагууд санаа зовж байна. Ялангуяа, төр-хувийн хэвшил боловсролын салбарт хэрхэн ажиллах эрх зүйн орчин тодорхой болоогүй энэ цагт, цэцэрлэгийн хүртээмжийн асуудлыг шийдвэрлэх нэрээр боловсролын төсөв хувийн хэвшил рүү урсах, боловсролын салбарт хувьчлал эрчимтэй явагдах вий гэдэгт иргэний нийгмийн байгууллагууд онцгойлон анхаарч байна.

## 10. Иргэний болон иргэний нийгмийн оролцоо

Сүүлийн жилүүдэд боловсролын салбарт ИНБ-ууд, маргинал бүлгийг төлөөлсөн ТББ-жждтай хамтран ажиллах байдалд эрс дэвшил гарч байна. Тухайлбал, боловсролын бодлого боловсруулах, төсвийн шинэчлэл, судалгаа, хэлэлцүүлэг, гэрээт ажил, зөвлөх үйлчилгээ зэрэг олон хэлбэрээр Боловсрол эвсэлтэй хамтран ажилласан. Мөн ТХЗ 4-ийн хэрэгжилтийн дунд хугацааны үнэлгээ хийхэд Боловсрол эвсэл хамтран оролцсон сайн жишээ байна.

Боловсролын багц хуулийн шинэчилсэн найруулгын ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд боловсролын чиглэлийн иргэний нийгмийн байгууллагын лобби, нөлөөлөл, олон талт судалгаа, чуулгануудын үр нөлөөгөөр хуулийн төсөлд ТХЗ-4-ийн үзэл санаа, тэгш хамран сургах чиглэлээр дэвшилтэт заалтуудыг тусгаснаар УИХ-д өргөн барьсан. Хэдий тийм боловч боловсролын эрх тэгш байдлыг хангахтай холбоотой заалтууд маргаантай, боловсролын чанарыг хянах, дээшлүүлэхтэй холбоотой заалтууд хангалтгүй байгааг иргэний нийгмийн зүгээс шүүмжлэлтэй хандаж байна.

Мөн эвслийн зүгээс ТХЗ-4а эрүүл аюулгүй орчин чиглэлээр Боловсролын ерөнхий газартай ажиллаж, үе тэнгийн дээрэлхэлтийг таслан зогсоох арга зүйг хамтран хэрэгжүүлж байна. Түүнчлэн, Үндэсний хөгжил шинэтгэлийн хороон дээр Сайн дурын илтгэлийн ТХЗ-4-өөр бичихэд 2019 онд зөвлөлдөж, харилцан санал солилцсон юм.

### Нэмэлт (cross-cutting) салбар хоорондын асуудлуудын хүрээ:

1. Сүүлийн Үндэсний сайн дурын илтгэлээс хойш гарсан дэвшил

Цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлж, СӨБ-д хамран сургалтыг нэмэгдүүлж байна:

Засгийн газрын зүгээс 2022 оны 5-р сард 218 дугаар “Нийслэлийн цэцэрлэгийн хүртээмжийг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолыг<sup>53</sup> баталсан. Уг тогтоолоор:

- Цэцэрлэгийн хамран сургах тойргийг шинэчлэх, өмчийн хэлбэр харгалзахгүй байх, ялангуяа нийслэлд улсын сургууль цэцэрлэгийн хүртээмж багатай газар үйл ажиллагаа явуулж буй хувьд хувийн

53 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530579450841>



хэвшилд хувьсах зардлыг хоёр дахин нэмэгдүүлж олгох буюу байр түрээслэх, худалдан авах, дэвшилтэт технологи ашигласан гэр цэцэрлэгийг алслагдмал газруудад ажиллуулах;

- Цэцэрлэгийн зориулалттай баригдаж буй барилга, байгууламжийг яаралтай ашиглалтад оруулахад анхаарах, нэмэлт зардлын эх үүсвэрийг тусгах;
- Аж ахуйн нэгж байгууллагууд дэргэдээ цэцэрлэг байгуулах, ажиллуулахыг дэмжих;
- Цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй хамтран сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалтад хамруулах;
- Багшийг сургаж бэлтгэх, давтан сургах, энэ чиглэлээр суралцаж байгаа оюутныг тодорхой ажлын байранд дадлагажуулах зэрэг үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж байна.

БШУЯ-аас 2022-2023 оны хичээлийн жилд СӨБ буюу цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлж, нэг ч хүүхдийг ард орхихгүй гэсэн ТХЗ-4 хэрэгжилтийг хангахад томоохон алхмыг хэрэгжүүлж,<sup>54</sup> салбарын сайдын мэдээлж буйгаар хүсэлт гаргасан хүүхэд бүрийг СӨБ-д хамруулах болжээ.<sup>55</sup> Тодруулал, 2022-2023 оны хичээлийн жилд гурван удаагийн элсэлтээр нийт 124 мянган хүүхдийг цэцэрлэгт хамруулснаас төрийн өмчийн цэцэрлэгт 94621, хувийн өмчийн цэцэрлэгт 30 мянган хүүхэд<sup>56</sup> хамрагдах болжээ.

Хувьсах зардлыг тооцох аргачлалыг шинэчилж, үр дүнд суурилсан санхүүжилтийн бодлогыг хэрэгжүүлж эхлэв:

Засгийн газрын 2022 оны 3-р сарын 91 дугаар тогтоолоор<sup>57</sup> “Төрийн болон орон нутгийн өмчит цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын байршил, хэв шинж, хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүр” аргачлалыг шинээр нэвтрүүлэв.

БШУЯ-ны мэдээлж буйгаар “Үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо”-нд шилжсэнээр “тоног төхөөрөмжийн нөхөн хангалт, хичээл практик, мэдээлэл технологи, багшийн хөгжлийг дэмжих, эрүүл мэндийг дэмжих зардлыг олгох болсон” дэвшил гарчээ. Мөн ТҮБД-3 ангиллаар цалинждаг байсан багш 850717 төгрөгийн цалин авдаг байсан бол одоо 1050000 болж 37 хувиар нэмэгдсэн бөгөөд 2022 онд ЕБС-ийн 12431 багшид 14,5 тэрбум төгрөгийн, СӨБ-ын 2906 багшид 3,2 тэрбум төгрөгийн урамшуулал олгосон байна.<sup>58</sup>

54 <http://itoim.mn/article/fJTiV/34270>

55 <https://www.meds.gov.mn/post/125079>

56 <https://montsame.mn/mn/read/307705>

57 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16468212335341>

58 <https://www.meds.gov.mn/post/125077>

Мөн салбарын яамны зүгээс 2021 онд хувийн сургуулиудад жилд 17,9 тэрбум төгрөгийн хувьсах зардал олгодгоос 10 сая ба түүнээс дээш төгрөгийн төлбөртэй 11 сургуульд олгодог 1 тэрбум төгрөгийн хувьсах зардалыг олгохгүй бөгөөд үүнийг хичээлийн хоцрогдол арилгах хөтөлбөрт зарцуулахаар болсноо<sup>59</sup> албан ёсоор мэдэгдэж, тэгш байдлыг нэмэгдүүлэхэд тодорхой дэвшил болсон шийдвэрийг гаргав.

Сургалтын чанарыг дээшлүүлэхэд ач холбогдол бүхий хэд хэдэн арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Цар тахлын улмаас сургалтын үйл ажиллагааны зайн хэлбэрт шилжсэний улмаас үүсэн сургалтын хоцрогдлыг БШУЯ-ны зүгээс албан ёсоор үнэлж, сурлагын хоцрогдлыг арилгах төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж<sup>60</sup> буй нь тун ач холбогдолтой байна. Ялангуяа, энэхүү хоцрогдлын талаарх мэдээллийг яамны зүгээс олон нийтэд танилцуулж, нээлттэй байв. Мөн ерөнхий боловсролын сургуулиудад үе тэнгийн дээрэлхэлтийг таслан зогсоох, мэргэжлийн сэтгэлзүйчийг ажиллуулах, багш нарын ёс зүйг дээшлүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна. БШУЯ-наас гурван сургууль тутмын нэг нь мэргэшсэн сэтгэл зүйчтэй болсон хэмээн мэдээлж байна.<sup>61</sup>

Боловсролын салбарт шинэчлэл гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бий болгож, салбарын байгууллагуудыг хагас бие даасан тогтолцоонд шилжүүлснээр төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна гэж үзжээ. Өмнө нь ийм төрлийн бодлогыг хэрэгжүүлсэн улс орнуудын алдааг сургамж болгож, бодлогоо цаасан дээр бодитой зураглаж хэрэгжүүлэх, сургуулиудыг эрэмбэлэн жагсаахгүй байх, сургуулиудад бие даасан байдлыг хангаж байгаа бол орон нутгийн иргэд, эцэг эхчүүдийн хяналтыг бий болгох зэрэгт анхаарах шаардлагатай байна.

### 1. Хэнийг ч үл орхих

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн зөвлөмжид<sup>62</sup> дурдахдаа:

- хүүхэд бүрийг боловсролын бүх шатны үйлчилгээнд тэгш хамруулан суралцахыг баталгаажуулах, ялангуяа эмзэг бүлгийнхний хүүхдүүдэд онцгой анхаарал хандуулах
- үндэстний болон хэлний цөөнхийн боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж бэхжүүлэхийг зөвлөсөн байдаг.

Эвслийн зүгээс энэ чиглэлд хэд хэдэн судалгаа, мониторингийг хэрэгжүүлж, санал зөвлөмжийг хэдийнэ танилцуулсан билээ. Өнгөрсөн

59 <https://www.meds.gov.mn/post/64934>

60 <https://www.meds.gov.mn/post/68019>;

61 <https://www.meds.gov.mn/post/124668>

62 Нэгдсэн үндэстний байгууллага, “Монгол Улсын хөгжлийн төлөв байдлын шинжилгээ 2021” <https://mongolia.un.org/mn/174973-mongol-ulsyn-khogzhiyn-tolov-baydlyn-shinzhilgee-2021>; HA/HRC/46/9 (UPR 2020);

хугацаанд олж илрүүлсэн асуудлаас онцлон дурдвал, ЕБС-ийн сургуулийн насны бүх хүүхэд сургуульд бүртгэлтэй боловч амьжиргааны түвшин, хөгжлийн бэрхшээл, шилжих хөдөлгөөний бүртгэл, хэл соёлын ялгаа, газарзүйн байршил, жирэмслэлт, төрөлт, хүчирхийлэлд өртөх зэрэг тодорхой шалтгааны улмаас сургууль завсардсан байна.<sup>63</sup> Мөн маргиналчлагдсан бүлгийн хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулах асуудалд зөвхөн боловсрол, сургалтын чиглэлээр авах арга хэмжээ хангалтгүй бөгөөд эрүүл мэнд, хоол тэжээл, хүүхэд хамгаалал, нийгмийн халамжийн ажил үйлчилгээнд цогцоор хамруулж байж шийдэгдэх салбар хоорондын асуудал гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой. Гэвч 2020 оны 9-р сараас эхлэн мөрдөж буй Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд мөн л дүйцсэн хөтөлбөрөөр суралцагчид орхигдсон байна.<sup>64</sup>

Мөн үндэсний цөөнхийн хүүхдүүдийн хувьд хэлбэрийн төдий тэгш эрх олгогдож байна. Торуулбал, тогтолцооны хувьд сурч боловсрох эрх хангагдаагүйг Баян-Өлгий аймгийн жишээнээс харж болно. Учир нь Монгол хэлний хуульд заасан хос хэлний хөтөлбөр боловсруулагдаж батлагдаагүй, аливаа ерөнхий боловсролын сургуулийн сургалтын төлөвлөгөөг салбарын сайд батлах ёстой боловч үндэсний цөөнх болсон казах, тува нар амьдардаг Баян-Өлгий аймгийн хувьд сургалтын төлөвлөгөөг БСУГ-ын дарга баталж байна. Мөн казах хэл дээр унших уран зохиолын ном, гарын авлага, сургалтын нэмэлт материалууд ховор байдгаас үндэсний соёл, уламжлалаа боловсролын тогтолцоогоор дамжуулан суралцахад бэрхшээлтэй.<sup>65</sup> Багш нарыг дэмждэг тогтолцоо бараг байхгүйтэй адил байна. Түүнчлэн, хот, суурин газар амьдарч буй казахууд эх хэлний асуудалд маш их санаа зовж байгаа нь судалгаанаас харагдаж байна. Тэд зөвхөн гэр бүлийн хүрээнд болон сүсэглэх үедээ л эх хэлээ ашиглах боломжтой байгаа нь казах иргэдийн эх хэлээ сурах, суралцах эрх нь зөрчигдөж байна гэж үзэж байна.<sup>66</sup>

63 “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл, “Тодорхой бүлгийн хүүхдүүдэд боловсрол эзэмшихэд тулгардаг саад тогторууд” чанарын судалгааны тайлан, Улаанбаатар 2020 он, 31 тал.

64 Мөн тэнд, 31 тал.

65 9 тал.

66 “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл, “Хос хэлний боловсролын өнөөгийн нөхцөл байдал” судалгааны нэгтгэсэн тайлан, Улаанбаатар хот, 2021 он. 46 тал.

Хавсралт 1:

### ТХЗ-4 БОЛОН “АЛСЫН ХАРАА-2050” БОЛОВСРОЛЫН ЗОРИЛТУУДЫН ХАРЬЦУУЛАЛТ

Тогтвортой хөгжлийн 4-р зорилт	“АЛСЫН ХАРАА-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогод туссан боловсролын зорилт
<p>“Бүх хүн тэгш хамруулсан, тэгш байдлыг хангасан, чанартай боловсрол эзэмших явдлыг баталгаажуулах ба бүх хүн насан туршдаа суралцах боломжийг хөхиүлэн дэмжих”<sup>67</sup></p>	<p><b>Зорилт 2.1.</b> Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ. <i>Боловсролын тогтолцоог бэхжүүлэхтэй холбоотой 2030 онд хэрэгжсэн байх үйл ажиллагаа:</i></p> <p>2.1.1. Боловсролын чиглэлээр суурь болон хавсарга судалгааг тогтмол хийж хэвших ба бүх шатны боловсролын сургалтын байгууллагын байршил, хүчин чадал, нөөц, нормативын нэгдсэн зураглал, судалгаа, шинжилгээний мэдээллийн санг бий болгон, судалгаа, нотолгоонд суурилсан бодлого, хөгжлийн төлөвлөлт, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх удирдлагын тогтолцоог сайжруулна.</p> <p>2.1.2. Боловсролын мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулан эрх, үүргийн оновчтой хуваарилалт хийж, олон талт түншлэлийг дэмжинэ.</p> <p>2.1.3. Мэргэжлийн холбоодтой хамтарч ажиллах, түншлэлийг бэхжүүлэн зарим төрлийн үйл ажиллагааг мэргэжлийн холбоодод шилжүүлж, бие даасан хараат бус үйл ажиллагаа явуулах зохицуулалт хийнэ.</p> <p>2.1.5. Боловсролын мэргэжлийн байгууллагуудын дэргэд түшиц сургалт судалгаа, инновацын нэгжүүдийг бий болгож ажил олгогч, мэргэжлийн холбоод, эрдэмтэн багш, судлаачдын түншлэлийг бэхжүүлнэ.</p> <p>2.1.6. Төрөөс хараат бус бие даасан хүний нөөцийн бодлогын үндэсний зөвлөл байгуулан салбар бүрийн мэргэжлийн холбоодтой хамтран мэргэшлийн үндэсний хүрээг тогтоож, хэрэгжүүлж, хөдөлмөрийн зах зээлийн нээлттэй нэгдсэн цахим мэдээллийн систем бий болгох, техник мэргэжлийн болон дээд боловсролын бодлого тодорхойлоход шаардлагатай мэдээллийг боловсролын салбарын мэдээллийн санд нэгтгэн хөтөлж, хэрэглэж хэвшинэ.</p> <p>2.1.7. Боловсролын байгууллагын бүх түвшинд дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, өөрийн үнэлгээний тогтолцоог чанаржуулж, соёлыг бий болгоно.</p> <p>2.1.23. Сэтгэл зүйч болон хүний хөгжлийн чиглэлээр хос мэргэжилтэн бэлтгэнэ.</p> <p>2.1.33. Боловсролын салбарын хүний нөөцийн цогц бодлого хэрэгжүүлж, чадвар суурилсан зарчмаар албан тушаал, мэргэжлийн хөгжлөө тодорхойлох боломжтой тогтолцоог бий болгох, салбарын хүний нөөцийн жендэрийн тэгш байдлыг хангах, хөдөө орон нутагт очиж ажиллах хүний нөөцийг орон байраар хангах зэрэг арга хэмжээг авна.</p> <p>2.1.38. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн удирдах ажилтанд тавигдах шаардлага, удирдах ажилтныг бэлтгэх, томилох тогтолцоо, ажил үүргийн хуваарийг шинэчилж, сургалтын чанарыг хангах чиг үүргийг нэмэгдүүлж, гүйцэтгэлийн үнэлгээг сайжруулан сургалтын байгууллагын менежментийн чадавхыг дээшлүүлнэ.</p> <p>2.1.42. Боловсролын салбарын мэдээллийн системийг бүрэн хөгжүүлж, бүх түвшинд нэвтрүүлэн салбарын бодлого, төлөвлөлт, хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагаанд хэрэглэж хэвшин, мэдээллийн аюулгүй байдлыг хангана.</p>

67 “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн албан бус орчуулга. Албан ёсны орчуулгад “inclusive” болон “equitable” нэр томъёоны ялгааг гаргахгүйгээр “тэгш” хэмээн буулгасан нь “бүгдийг тэгш хамруулах, хэнийг ардаа үлдээхгүй” гэсэн ТХЗ-ын утга санааг бүрэн илэрхийлж чадахгүй байна.

Зорилтууд <sup>68</sup>	Үзүүлэлт	"Алсын хараа-2050" хөгжлийн баримт бичгийн 2030 гэхэд хэрэгжсэн байх үйл ажиллагаа
Зорилт 4.1 2030 он гэхэд бүх эрэгтэй, эмэгтэй хүүхдүүд үнэ төлбөргүй, тэгш, чанартай бага болон дунд шатны боловсролыг эзэмшиж, холбогдох, үр дүнтэй эрдэм мэдлэгтэй болсон байх	4.1.1. (i) Унших болон (ii) математик бодох наад захын чадварыг эзэмсэн (а) 2/3-р анги, (b) Бага анги төгссөн, (c) Дунд анги төгссөн хүүхэд, үр дүнтэй эрдэм мэдлэгтэй залуучуудын эзлэх хувь, хүйсээр	2.1.21. Суралцагчдын сурлагын амжилтад нөлөөлөх хүчин зүйлийн судалгааг тогтмол хийж үр дүнд үндэслэн бодлого, төлөвлөлт хийж хэвшинэ. 2.1.14. Сургалтын байгууллагын санхүүжилтийг төгөлдөржүүлэн, суралцагч нэг бүрийг амжилттай суралцахад чиглүүлнэ. 2.1.8. Боловсролын байгууллага, сургалтын хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын хөндлөнгийн хяналт шинжилгээг олон улсын жишиг аргачлалаар хийдэг тогтолцоонд шилжиж төрөөс хараат бус бие даасан институцийг бэхжүүлнэ.
Зорилт 4.2 2030 он гэхэд бүх эрэгтэй, эмэгтэй хүүхдүүдийг бага боловсролд бэлтгэж зүйн хөгжлийн хувьд зөв бага насны хүүхдүүдийг чанартай үйлчилгээ, тусламж, сургуулийн өмнөх боловсролоор хангах	4.2.1. Эрүүл мэндийн байдал, сэтгэх, суралцах чадвар, нийгэм-сэтгэл бэлтгэж зүйн хөгжлийн хувьд зөв төлөвшилд яваа 5-аас доош насны хүүхдүүдийн эзлэх хувь, хүйсээр 4.2.2. Сургуульд орох албан ёсны насанд хүрэхээс нэг жилийн өмнө зохион байгуулалттай сургалтад хамрагдагсдын эзлэх хувь, хүйсээр	2.1.13. Сургуулийн өмнөх боловсрол нь хүүхдийн төлөвшил, хөгжлийн суурь үе хэмээн үзэж цэцэрлэгийн үйлчилгээний болон сургалтын чанарыг сайжруулахад чиглэсэн цогц үйл ажиллагааг зохион байгуулна. 2.1.18. Цэцэрлэгийн хүүхдийн хоолны мөнгийг 1-3, 4-6 настай хүүхдийн хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодис, аминдэм, эрдэс бодисын хэмжээг үндэслэн жил бүр шинэчлэн тогтооно. 2.1.18. Хүүхэд харах үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, 1-2 насны хүүхдийг хамруулах боломжтой болгох эрх зүйн орчныг бүрдүүлж, энэ төрлийн үйлчилгээ эрхэлж байгаа байгууллагад тавигдах шаардлага, стандартыг батлан, дагаж мөрдүүлнэ.
Зорилт 4.3 2030 он гэхэд бүх эрэгтэй, эмэгтэй хүнд хямд үнэтэй, чанартай болон дээд боловсрол, мэргэжлийн боловсролыг тэгш авах боломжийг бүрдүүлэх	4.3.1. Сүүлийн 12 сарын хугацаанд албан болон албан бус боловсрол, сургалтад хамрагдсан хүрэгчид, насанд залуучуудын эзлэх хувь, хүйсээр	2.1.9. Их, дээд сургууль, политехникийн коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, ерөнхий боловсролын сургуулийг тухайн орон нутаг, бус нутгийн хүний хөгжлийн төв болгон хөгжүүлж бүх насны иргэд, нийгмийн салбар бүрийг хамарсан насан туршийн боловсролын нээлттэй, уян хатан тогтолцоог бэхжүүлнэ. 2.1.10. Их, дээд сургууль, политехникийн коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүд төгсөгчдийнхөө мэргэжил дээшлүүлэх асуудлыг хариуцдаг тогтолцоог бий болгож, насан туршийн боловсролын үйлчилгээний чиглэлийг нэмэгдүүлэн, насанд хүрсэн суралцагчдын ажил эрхлэх үр чадвар, амьдрах чадварын сургалтын хүрээнд төдийгүй шинэ чадвар эзэмшүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөр бий болгож хэрэгжүүлэхэд олон талт оролцоог хангана.
Зорилт 4.4 2030 он гэхэд ажил эрхлэх, зохистой хөдөлмөр, хувийн бизнес эрхлэх холбогдох чадвартай, түүний дотор техник, мэргэжлийн чадвартай насан хүрэгсдийн тоош [x] хувиар нэмэгдүүлэх	4.4.1 Мэдээлэл харилцаа холбоо, технологийн үйлдвэрлэл, хувийн бизнес эрхлэхэд зарцуулсан хөрөнгө, үр дүнд хувь, хүйсээр	2.1.22. Сурагч болон багшид сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, суралцагчдад мэргэжлээ сонгох, ирээдүйгээ төлөвлөхөд нь зөвлөн туслах чиг үүрэгтэй сэтгэл зүйч, мэргэжилтнийг сургууль бүрд ажиллуулна. 2.1.27. Шинжлэх ухаан, технологи, инновацын хөгжилд дээд боловсролын сургалтын байгууллагуудын оруулах хувь, нэмэр, оролцоог нэмэгдүүлж, бус нутагтаа өрсөлдөх чадвартай үндэсний судалгааны их сургууль байгуулна. 2.1.32. Мэргэжлийн болон дээд боловсролын түвшинд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөхүйц хэмжээнд бэлтгэхэд шаардлагатай хүртээмжтэй, тохирох хэрэглэгдэхүүн, багш, мэргэжилтэн бүхий сургалтын орчин, нөхцөлийг бүрдүүлнэ.

68 Албан ёсны эх сурвалж: <https://sdg.1212.mn/Home/Detail?id=4>

<p>Зорилт 4.5 2030 он гэхэд боловсролын байгууллагад суралцагсдын жендерийн зохицтой харьцааг хангаж, эмзэг бүлэг, түүний дотор хөгжлийн бэрхшээлтэй хүймүс, нутгийн уугуул хүмүүс, эмзэг бүлгийн хүүхдүүдэд бүх шатны боловсрол, мэргэжлийн сургалтыг тэгш авах боломжийг бүрдүүлэх</p>	<p>4.5.1 Энэ жагсаалтад орсон боловсролын бүх үзүүлэлтүүдээр задлан гаргаж болох Тэнцвэрийн индекс (эрэгтэй/хот/хөдөө орон нутгийн, баян чинээлэг/андуу, доогуур орлоготой бүлэг болон хөгжлийн бэрхшээлтэй, өртсөн мөргөлдөөнд гэх зэрэг мэдээлэл өгөх боломжтой бусад үзүүлэлтээр)</p>	<p>2.1.11. Боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй, эрсдэлт бүлгийн суралцагч нэг бүрд шаардлагатай дэмжлэгийг үзүүлж, боловсролд тэгш хамруулна.</p> <p>2.1.15. Малчин, шилжин суурьшигч, орлого багатай өрхийн, ялгаатай болон тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдүүдэд сургуулийн өмнөх боловсрол тэгш олгох боломж, орчин нөхцөлийг бүрдүүлж, эцэг эх, асран халамжлагчдыг чадавхжуулах замаар тэдний оролцоонд түшиглэсэн хүүхдийн хөгжлийг дэмжинэ.</p> <p>2.1.17. Хүүхэд бүрийн онцлог, ялгаатай байдлыг тооцон сургалтыг чанартай зохион байгуулахад чиглэсэн тусгай хэрэгцээт боловсролын мэргэжилтнийг цэцэрлэг бүрд ажиллуулна.</p>
<p>Зорилт 4.6 2030 он гэхэд бүх залуус, эрэгтэй, эмэгтэй нас хүрэгсдийн хамгийн багадаа [X] хувийг бичиг үсэг, тооны мэдлэгтэй болгох</p>	<p>4.6.1 Тухайн насны бүлгийн хүмүүсийн дотор (a) бичиг үсгийн болон (b) тоо тооллын анхан шатны үйлдлийн наад захын мэдлэг, чадвартай хүн амын эзлэх хувь, хүйсээр</p>	
<p>Зорилт 4.7 2030 он гэхэд тогтвортой хөгжлийн тогтвортой мэдлэг, амьдралын хүний эрх, жендерийн тэгш байдал, энх тайван болон хүч үл хэрэглэх соёлыг төлөвшүүлэх, дэлхийн иргэн байх, соёлын олон янз байдал болон тогтвортой хөгжилд соёлын оруулж буй мэдүүлэх замаар тогтвортой хөгжлийг хөхүүлэх дэмжихэд шаардлагатай мэдлэг, ур чадварыг бүх суралцагчдад олгох</p>	<p>4.7.1 (i) Дэлхийн боловсрол төгш жендерийн байдал, хүний эрхийн асуудлыг хамруулсан (ii) тогтвортой хөгжлийн боловсролыг (a) үндэсний боловсролын бодлого, (b) сургалтын хөтөлбөр, (c) багш нарын боловсрол болон (d) суралцагчийн үнэлгээнд тусгасан байдал</p>	<p>2.1.20. Бага, дунд боловсролын чанарыг дээшлүүлж, сургалтын хөтөлбөр, агуулга, арга зүйд монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, хувь хүний хөгжил, төлөвшил, хос хэл, хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлийг тусган хэрэгжүүлнэ.</p>

<p>Зорилт 4.а Хүүхэд, хөгжлийн бэрхшээл, жендерийн мэдрэмжтэй боловсролын байгууллагыг бэхжүүлэн сайжруулж, хүн бүрийг аюулгүй, хүртээмжтэй, үр дүнтэй суралцах орчноор хангах</p>	<p>4.а.1 (а) Цахилгаан эрчим хүчинд холбогдсон, (b) сургалтын зорилгоор ашиглах интернэттэй; (c) сургалтын зорилгоор ашиглах компьютертэй; (d) хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулсан дэд бүтэц, ёургалтын материалгаар хангагдсан, (e) ундны усаар хангагдсан; (f) эрэгтэй, эмэгтэй ариун цэврийн байгууламжтай; and (g) гар угаах өрөөтэй (WASH үзүүлэлтийн тодорхойлолтын дагуу) сургуулиудын эзлэх хувь</p>	<p>2.1.12. Бүх шатны сургалтын байгууллагын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан, стандарт, чанарын шаардлага хангасан тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлж, цэцэрлэг, сургуулийн анги, бүлэг дүүргэлтийг норматив хэмжээнд хүргэнэ.</p> <p>2.1.19. Сургуулийн дотуур байр, ногоон хөгжлийн байгууламж, спортын болон урлагийн заал, цайны газар, мэдээлэл зүйн сургалтын танхимыг тохижуулж, сургалтын байгууллагын орчны стандартыг хангах, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулсан тохируулгат орчныг бүрдүүлж, цэвэр ус, ариун цэврийн байгууламжийг хүүхэд, хэрэглэгчдэд эзэлтэй болгох ажлыг үе шаттайгаар төвлөвөж хэрэгжүүлнэ.</p> <p>2.1.24. Сургуулийн дотуур байрны менежментийг сайжруулан багш нарын ажлын ачааллын 10 хүртэлх хувьд дотуур байранд сурагчдын хөгжлийг дэмжих чиглэлээр хийсэн сургалт, хөгжлийн үйл ажиллагааны цагийг тооцдог байх зохицуулалт хийж, дотуур байрны хүүхэд хамгааллыг сайжруулна.</p> <p>2.1.25. Сурах бичиг, сургалтын нэмэлт хэрэглэгдэхүүн, цахим болон зайн сургалтын хүртээмжийг нэмэгдүүлж, суралцагчдын ялгаатай хэрэгцээг хангасан байхаар боловсруулж, түгээнэ.</p> <p>2.1.26. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үндэсний тогтолцоог хөгжүүлэн бүх сурагч үдийн хоолны хөтөлбөрт хамрагдаж, сургууль бүр стандартын шаардлага хангасан хоол үйлдвэрлэлийн байр, тоног төхөөрөмж, хүний нөөцтэй байна.</p> <p>2.1.43. Нээлтэй боловсролын тогтолцоог бий болгон цахим болон зайн сургалтын нэгдсэн платформыг хөгжүүлэн бүх шатны боловсролын сургалтын байгууллагыг цахим хэрэглээнд бүрэн шилжүүлж, бүх насны суралцагч, иргэдэд зориулсан цахим сургалтын хөтөлбөр, агуулга боловсруулан түгээнэ.</p>
<p>Зорилт 4.б 2020 он гэхэд хөгжингүй болон хөгжиж буй бусад орнуудад дээд боловсрол, түүний дотор мэргэжлийн сургалт, мэдээлэл, харилцаа холбооны технологи, техникийн, инженерийн, шинжлэх ухааны сургалтад суралцуулах зорилгоор хөгжиж буй орнууд, ялангуяа нэн буурай хөгжилтэй болон жижиг арлын хөгжиж буй улс орнууд, Африкийн орнуудад олгох сургалтын тэтгэлгийн тоог дэлхийн хэмжээнд [X] хувиар нэмэгдүүлэх</p>	<p>4.б.1 Сургалтын тэтгэлэгт зориулсан хөгжлийн болон ёсны тусламжийн хэмжээ, салбараар болон сургалтын төрлөөр</p>	<p>2.1.28. Нийгэмд нэн чухал боловсрол, эрүүл мэнд, мэдээллийн технологийн болон эдийн засгийн тэргүүлэх чиглэлээр хүний нөөцийг бэлтгэж, төр, хувийн хэвшлийн дэмжлэг, хамтын ажиллагааны үр нөлөөтэй зохицуулалт бүрдүүлж, стратегийн ач холбогдол бүхий чиглэлээр гадаадад суралцагчдыг төрөөс дэмжинэ.</p> <p>2.1.29. Их, дээд сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийн хөтөлбөрүүдийн ангиллыг элсэлтийн бодлого, ажиллах хүчний тооцоотой уялдуулж шинэчилнэ.</p> <p>2.1.30. Мэргэжлийн, техникийн болон дээд боловсролын сургалтын байгууллагуудыг олон улсын шаардлагад нийцүүлэн хөгжүүлж, төгсөгчдийн ажил эрхлэлтийн болон ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгаанд үндэслэн хамтын ажиллагааг бэхжүүлж, хичээлийн 20-ос доошгүй багц цагийг дадлагын хөтөлбөрт шилжүүлэн, сургалтын хөтөлбөрийг сайжруулах бөгөөд орон нутаг дахь бүс нутгийн онцлог, эдийн засгийн тэргүүлэх чиглэлтэй уялдсан байна.</p> <p>2.1.31. Анагаах ухааны боловсрол олгох их сургууль нь харьяа, түшиц эмнэлэгтэй байж, сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны дадлага хосолсон чанартай боловсрол эзэмшүүлснээр чадварлаг эмч, мэргэжилтэн бэлтгэнэ.</p>



<p>Зорилт 4.с 2030 он гэхэд хөгжиж буй орнууд, нэн буурай хөгжилтэй болон арлын хөгжиж буй улс орнуудад багш чиглэлийн сургалтын олон улсын хамтын ажиллагаагаар дамжуулан дадлага туршлагатай багш нарын хангамжийг хувиар нэмэгдүүлэх</p>	<p>4.с.1 Тухайн шатны сургуульд багшлах үр чадварын хамгийн багш шатны сургалтад болохоосоо өмнө болон багш болсны дараа хамрагдсан багш нарын эзлэх хувь (а) сургуулийн өмнөх, (b) бага, (с) дунд, (d) ахлах сургуулийн багш нарын дунд</p>	<p>2.1.16.Цэцэрлэгийн багшийн ажлын чанарыг сайжруулах, сургалтын үйл ажиллагаанд бэлдэх, хүүхдийг ажиглах, судалгаа хийх, өөрийгөө хөгжүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлж, 2021 оноос эхлэн 30-аас дээш бүлэг дүүргэлтэй ангид, 2023 оноос эхлэн бүлэг бүрд хоёр ээлжийн бүлгийн багш ажиллуулна.</p> <p>2.1.34.Багшийн стандартыг мэргэжлийн, заах арга зүйн, судалгааны, мэдээлэл, харилцаа, холбооны технологийн, гадаад хэлний гэх мэт чадваруудаар ялган тодорхойлж, багшийн хөгжил, хүний нөөцийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлж, бүх шатны сургалтын байгууллагыг мэргэжлийн багшаар хангана.</p> <p>2.1.35.Ерөнхий боловсролын сургуульд шаардлагатай бага ангийн, тусгай хэрэгцээт болон мэргэжлийн багш нарыг бэлтгэж, мэргэжлийг нь тогтмол дээшлүүлнэ.</p> <p>2.1.36.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, туслах багшийн ажлын ачааллыг ажлын байр, хөдөлмөрийн онцлогтой уялдуулж, тэдний үйл ажиллагааг үр дүнгээр нь үнэлж, цалин хөлс, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгон бодит цалингийн хэмжээг улсын дунджаас дээш байлгана.</p> <p>2.1.37.Багш бэлтгэх сургалтын чанарын баталгаажуулалтын тусгай шалгуур үзүүлэлт бий болгож, сургалтын хөтөлбөрт тавигдах шаардлагыг нэмэгдүүлж, сургалтын байгууллагад багшлах эрхийн баталгаажуулалтыг үе шаттай хийдэг тогтолцоог бэхжүүлнэ.</p> <p>2.1.39.Багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх тогтолцоог шинэчилж, багш өөрөө санаачилгаараа хөгжих тогтолцоог бэхжүүлнэ.</p> <p>2.1.40.Багшийн хөгжилд дэмжлэг үзүүлэх сургалт арга зүйн байгууллагын чадавхыг дээшлүүлж, үйл ажиллагааг өргөтгөн багш бэлтгэдэг их, дээд сургуулиудад түшиглэсэн төвүүд бий болгож хамтын ажиллагааг нь дэмжинэ.</p> <p>2.1.41.Багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх сургалт, үйл ажиллагаанд олон талт оролцоог хангаж сургалт явуулдаг төр, төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлнэ.</p> <p>2.1.44.Багш нарын мэдээлэл, харилцаа, холбооны технологийг сургалтад ашиглах, цахим, зайн сургалт хөтлөх, англи хэлний чадварыг дээшлүүлэх, ерөнхий боловсролын сургуулийн мэдээлэл, харилцаа, холбооны технологийн сургалтын агуулга, стандартыг олон улсын түвшинд хүргэж суралцагчдад цахим бичиг үсгийн боловсрол олгох, цахим орчинд аюулгүй байдлаа хангах чадвар олгох, иргэд, олон нийтэд зориулсан мэдээлэл, харилцаа, холбооны технологийн чадварыг дээшлүүлэх сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах ажлыг эрчимжүүлж, сургалт явуулдаг бүх төрлийн байгууллагын оролцоог хангана.</p>
---	--	--



**1. Засаглалын болон бодлогын хүрээ**

- Боломжтой бол ТХЗ-ын хэрэгжилтийг хянах засаглалын механизмын онцлог нь юу вэ? Засаглалын механизм нь байгаа Зөвлөл, Хороо дээр суурилсан уу? Эсхүл шинээр байгуулсан Зөвлөл, Хороо юу?
- Засаглалын механизмыг төрийн аль оролцогч хянаж, удирдлагаар хангадаг вэ? ЗГ-ын тэргүүн үү? Төрийн тэргүүн үү? Засгийн газрын гишүүн үү? Олон яамнаас бүрдсэн бүтэц үү? УИХ-ын хороо юу?
- Бүрэн эрхийн тодорхой байдал, төрийн бус оролцогчдыг хамруулсан байдал, оролцооны механизм, ажлын хэсгүүдийн ажлын арга зүй, нөөц гэх мэт танай улсын засаглалын механизмын онцлог юу вэ?
- Засаглалын болон бодлогын хүрээгээр УИХ-аас ямар нэг хяналт шалгалт, санал дүгнэлт гаргасан уу? Харэв тийм бол холбогдох хороод, тэдгээр нь засаглалын механизмд хэрхэн нийцэж байгаа мөн сонгогдсон гишүүдийн боловсруулсан бодлогын байр суурийг жагсаана уу.
- Орон нутгийн засаг захиргааг засаглалын үйл явцад хамруулдаг уу? Хэрэв тийм бол яаж?

**2. Үндэсний хөгжлийн төлөвлөгөө, стратеги, төсөв**

- Танай улсын Засгийн газар ТХЗ-дыг үндэсний бодлогын хүрээнд тусгасан уу? ТХЗ-ын хүрээг үндэсний хөгжлийн төлөвлөгөө холбогдох стратегидаа тусгасан уу? ТХЗ-ыг тусдаа ТХЗ-ыг хэрэгжүүлэх стратегийн баримт бичигт тусгасан уу? Засгийн газар үндэсний хөгжлийн төлөвлөгөө, эсхүл ТХЗ-ын стратегиа боловсруулахдаа оролцооны процессд тулгуурласан уу? Төлөвлөгөө, стратегийг боловсруулахдаа зөрүү-шинжилгээнд гар-analysis тулгуурласан уу? Хэрэв тийм бол энэ шинжилгээ бодлогод суурилсан байсан уу? Эсхүл өгөгдөлд суурилсан байв уу? Эсхүл хоёуланд нь суурилсан байсан уу?
- Үндэсний ТХЗ-ын хүрээнд бодлогын уялдааг хэр зэрэг үр дүнтэй хангадаг гэж боддог вэ? Тогтвортой хөгжлийн гурван хэмжигдэхүүний (нийгэм, байгаль орчин, эдийн засаг) хоорондоо харилцан хамаарал бүхий мөн чанарыг бодлогын арга барилдаа хэрхэн хүлээн зөвшөөрч, тусгадаг вэ? “Жимсийг нь түүх” гэж аль нэг ТХЗ-ыг онцлодог уу эсхүл бүх ТХЗ-ыг ижил тэгш анхаардаг уу?
- ТХЗ-ыг хэрэгжүүлэх зардлыг тооцож, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон уу? Жишээ нь, нийгмийн хамгаалал, боловсрол, эрүүл мэнд, тогтвортой дэд бүтэц, байгаль орчны хамгаалал, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах дасан зохицоход зориулсан төсвийн санхүүжилтийн түвшин хэд вэ?
- 2030 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтийн тухай үндэсний тодорхой төлөвлөгөө бий юу? Улсын төсөв 2030 хөтөлбөртэй нийцдэг үү? Олон улсын хандивлагч/хөгжлийн туншүүд ямар үүрэг гүйцэтгэдэг вэ?

**3. Институцийн дэмжлэг – Тодорхой эрх үүрэг бүхий төрийн байгууллагууд**

- ТХЗ-ыг хэрэгжүүлэх үүрэгтэй төрийн байгууллагууд байгаа эсэх, байгаа бол танилцуулна уу.
- ТХЗ-ын хэрэгжилтийг хангах чиглэлээр төрийн байгууллагуудаас тодорхой арга хэмжээ авч байна уу?
- Засгийн газраас ТХЗ-ыг хэрэгжүүлэх нэгдсэн (олон-агентлаг, олон-яамыг хамруулсан) арга барилыг хэрэгжүүлж байна уу?
- Тодорхой байгууллагуудад хуваарилсан тодорхой хүрээний асуудлууд байдаг уу?

<p><b>4. Үндэсний түвшинд бодлого, төлөвлөгөө, стратеги хэрэгжүүлэх нь</b></p> <ul style="list-style-type: none"> <li>– Ахиц дэвшлийн шалгуур үзүүлэлтүүдээр ТХЗ бүрийг үнэлэхэд гарсан тодорхой ололт амжилтыг тоймлон хэлнэ үү.</li> <li>– 2030 онд хүрэхээр төлөвлөсөн зорилтот түвшинүүдээс илүү их анхаарч ажиллах шаардлагатай байгаа асуудлын тухай хуваалцана уу.</li> </ul>
<p><b>5. Орон нутгийн түвшинд бодлого, төлөвлөгөө, стратеги хэрэгжүүлэх нь</b></p> <ul style="list-style-type: none"> <li>– 2030 Хөтөлбөр болон ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд орон нутгийн захиргаа идэвхитэй оролцдог уу? Хэрэв тийм бол яаж?</li> <li>– Орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөнд ТХЗ-ыг нэгтгэх эсхүл хөгжлийн төлөвлөгөөг ТХЗ-той нийцүүлэх үйл явцыг хэрэгжүүлсэн үү?</li> <li>– Орон нутагт хэрэгжүүлсэн, хянасан тухай сайн жишээ байна уу?</li> </ul>
<p><b>6. Олон нийтийн мэдлэг чадавхийг хөгжүүлэх нь</b></p> <ul style="list-style-type: none"> <li>– Тогтвортой хөгжлийн 2030 Хөтөлбөр болон ТХЗ-дыг бүрэн эхээр нь үндэсний болон орон нутгийн хэл рүү орчуулсан уу? Ямар хэл рүү орчуулсан бэ? Орчуулгыг хэн хийсэн бэ?</li> <li>– Боловсролын байгууллагууд, судлаачид ТХЗ-ын тухай дүн шинжилгээ хийх олон нийтэд хүргэхдээ хэр зэрэг идэвхитэй байдаг вэ?</li> <li>– Иргэний нийгмийн байгууллагууд үйл ажиллагааныхаа хүрээг тодорхойлохдоо 2030 хөтөлбөрийг ашиглаж байна уу?</li> <li>– Танай улсад ТХЗ-оор чадавхаа хөгжүүлэхэд ямар дэмжлэгүүлдэг вэ?</li> <li>– НҮБ-ын агентлаг, иргэний нийгмийн байгууллагатай хамтарч ажиллах боломж байдаг уу?</li> <li>– Та иргэний нийгмийн байгууллагад дутагдаж буй, зайлшгүй хөгжүүлэх шаардлагатай ямар ур чадварыг тодорхойлж хэлэх вэ?</li> </ul>
<p><b>7. Хяналт, үнэлгээ, өгөгдөл &amp; тайлагнах механизм</b></p> <ul style="list-style-type: none"> <li>– Танай улсад хяналт, хариуцлага тооцох албан ёсны институт бүхий тогтолцоо байгаа юу?</li> <li>– Энэхүү тогтолцоо нь хэр зэрэг нээлттэй, ил тод вэ? Энэ тогтолцоо нь жил бүр эсхүл хоёр жил тутам зохион байгуулагддаг олон талын оролцоотой тайлагнах үйл явцад бүрэн институтлагдсан уу?</li> <li>– Танай улсад гарч буй дэвшлийг харуулахын тулд нотлох баримт, задаргаа бүхий өгөдлийг хамтад нь ашиглах талаар ахиц гарч байна уу? Ямар өгөдлийг задаргаатай болгож байна?</li> <li>– Орлого, хүйс, нас, яс үндэс, шилжин суурьшилт, хөгжлийн бэрхшээл, газар зүйн байршил зэрэг танай улс орны онцлогт тохирсон бусад шинжээр задаргаатай өгөгдөл, нотолгоогоор хангах, хянахад иргэний нийгмийн байгууллагыг урьдаг уу? Хэрэв тийм бол, дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү.</li> </ul>
<p><b>8. Ил тод байдал, хариуцлага, мэдээлэл авах</b></p> <ul style="list-style-type: none"> <li>– ТХЗ-оор бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явц нь хялбар олдох, хуучраагүй, үнэн мэдээлэл, өгөгдөлд суурилдаг уу?</li> <li>– Албан ёсны өгөгдлийг ойлгуулах ил тод процесстой юу?</li> <li>– Авлига, хууль бус үйлдэлтэй тэмцэх тодорхой бодлого, ямар нэг албан ёсны журам мөрддөг үү?</li> </ul>

## 9. Олон талын түншлэл

- Үндэсний төлөвлөгөөний хэрэгжилтэнд янз бүрийн талуудын (төр, иргэний нийгэм, үйдвэрчний эвлэл, хувийн сектор, эрдэмтэд, орон нутгийн захиргаа, хөгжлийн түншүүд, УИХ-ын гишүүд г.м.) оролцоо ямар түвшинд байна вэ? Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд өргөн хүрээний салбар хоорондын горизонтал түншлэл байна уу?
- Талуудын хоорондох түншлэлийг та хэрхэн үнэлэх вэ? Харилцан хариуцлага тооцох механизм байна уу? Талууд хоорондоо ижил тэгш харилцаатай юу?
- Өргөн хүрээний түншлэлд ямар боломж, сорилт тулгарч байна?

## 10. Иргэний болон иргэний нийгмийн оролцоо

- 2030 Хөтөлбөрийг боловсруулах болон батлагдсан цагаас Та ТХЗ-ийг хэрэгжүүлэх засаглалын институц эсхүл холбогдох яамтай бодлогын хэлэлцүүлгийг тогтмол хийж байсан уу?
- Хэрэгжилт, хяналтад иргэний нийгмийн зүгээс хувь нэмрээ оруулах өөр арга зам бий юу? Энэ оролцоог дээд түвшиний уулзалтаар зохион байгуулсан уу? Ажлын хэсэг, техникийн бүлгээр үү? Албар бус зөвлөлдөх уулзалтаар уу? Тусдаа семинар, воркшопоор уу? Эдгээр орон зай нь тодорхой бүрэн эрх, арга зүй, нөөцөөс үр шимийг хүртдэг үү?
- Ахиц дэвшлийн үнэлгээний тухайд, ҮСДИ-ийг боловсруулах олон нийтийн хэлэлцүүлэгт иргэний нийгмийн хувь нэмрийг оруулахаар урьсан уу? Хэрэв тийм бол урилгыг яаж өгсөн, хэнийг урьсан бэ?
- Хэрэв тийм бол, энэ эерэг өөрчлөлт нь хэрэгжүүлэх үйл явцад, ялангуяа бодлогын яриа хэлэлцүүлэгт оролцох цаашдын боломжийг олгоно гэж та бодож байна уу?
- Танай Засгийн газар ИНБ-ын төлөөллийг ӨТҮТЧ-д оролцох төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд оруулах, эсхүл ҮСДХ-аар илтгэл тавиулсан уу?
- Хэрэв тийм бол, Танай Засгийн газар энэ оролцоог дэмжихийн тулд санхүүжилт олгосон уу?

## Нэмэлт (cross-cutting) салбар хоорондын асуудлуудын хүрээ:

### 1. Сүүлийн ҮСДИ-ээс хойш гарсан дэвшил

- Хэрэв танай улс одоо хоёр дох эсвэл дараачийн ҮСДИ хийх гэж байгаа бол өмнөх ҮСДИ-д илэрсэн дутагдлыг хэрхэн зассан бэ?
- Өмнөх ҮСДИ-ийг танилцуулснаас хойш түүний мөрөөр ямар нэгэн арга хэмжээ авсан уу?
- Хэрэв “ТИЙМ” бол, өмнөх ҮСДИ-ээс хойш ИНБ-ууд ямар оролцоотой байсан бэ?

### 2. Хэнийг ч үл орхих

- Таны туршлагаас харахад, 2030 хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэсний стратеги, үндэсний хөгжлийн төлөвлөгөөнд хамгийн ядуу, хамгийн хэмээг, хамгийн ард хоцорсон хэсгийн асуудлыг хир зэрэг тусгасан бэ?
- Эдгээр гадуурхагдсан бүлгийн үндэсний тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, бодлого боловсруулах, хянах үйл явцад оролцох боломжийг та хэрхэн үнэлэх вэ?
- Засгийн газраас бодлого боловсруулах болон зорилтот түвшин, эсхүл шалгуур үзүүлэлтийг тодорхойлох үйл явцын институцийн удирдамжинд “хэнийг ч үл орхих” зарчмыг тусгах нэгдсэн арга барилыг боловсруулсан уу?
- Бид танай улс дахь гадуурхагдсан бүлгүүдийн тухай илүү мэдэх сонирхолтой байна. Гадуурхагдсан гэж бусдаас илүү ядуурал, ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэлд өртөх, оролцоогоо хангаж чадахгүй байх эрсдэлтэй хүмүүсийг хэлж байна. Танай улсад ямар бүлгийн хүмүүсийг та хамгийн маргинал бүлэгт хамрагдана гэж үзэж байна вэ? (Та нэгээс илүүг сонгож болох ба мөн хамааралтай бүлгийг нэмж болно)

## “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн ТУНХАГ

Боловсрол нь хүн бүрийн өдөр тутмын амьдралд, насан турш нөлөөлөх үндсэн эрх, хүний хөгжлийн түлхүүр бөгөөд иргэн бүрт чанартай боловсрол олгох нь төрийн хүлээх гол үүрэг хариуцлага гэдэгт итгэн;

Өнөөгийн тогтолцоонд боловсролыг явцуу тодорхойлдог, хүн бүрийн ялгаатай байдлыг харгалздаггүй, ялгаварлан гадуурхдаг, хангалттай санхүүжилт олгодоггүй зэргээс шалтгаалан бодлого төлөвлөх, хэрэгжүүлэх үйл явцад цогц хандлага дутагдаж; боловсролын тогтолцооны үр өгөөж нь хувь хүний хүсэл тэмүүлэл, нийгмийн эрэлт хэрэгцээнээс асар зөрүүтэй байсаар ирсний улмаас үнэ цэнэтэй амьдарч, амьдралын чанараа дээшлүүлэх боломж олгохгүй байгаад сэтгэл зовнин;

Энэ нь эрх мэдлийн шударга бус бүтцийг бий болгож, тэгш бус байдлыг хадгалж үлдэх арга зам болж байгааг эсэргүүцэн;

Боловсролын чанар, хүртээмж, хариуцлагатай байдлын төлөө хүчээ нэгтгэн ажиллаж, энэ үйл явцад хувь хүн, иргэний нийгмийн байгууллага, бүлгүүдийг өргөнөөр татан оролцуулж, өргөн суурьтай, зохион байгуулалттай, хүчтэй хөдөлгөөн бий болгохыг чухалчлан;

Энэ үйл явцад нийгмийн бүх бүлэг, ялангуяа эрх мэдлийн цөөнхийн оролцоог хангахыг онцлон;

Иргэд, бүлгүүдийн мэдлэг, чадварыг хөгжүүлж, тулгарсан асуудлаа гаргаж ирэх, шийдлийг шаардах, хариуцлага тооцох чадавхтай болоход нь дэмжлэг үзүүлэхийг эрмэлзэн;

Боловсролын тогтолцоог хүний мэдэх, бүтээх, хүний ёсоор хамтран амьдарч, нэр төртэйгээр оршиход суралцахуйц, хувь хүний потенциал, чадвар, чадавхыг нээж, эерэг зан үйл, хандлагыг төлөвшүүлэхэд чиглэгдсэн, хүмүүнлэг, ардчилсан, хүн бүрийн эрхийг хангасан, тэгш хүртээмжтэй болгон өөрчлөхийг эрхэмлэн;

Хүүхэд, эцэг эх, багш, орон нутгийн бүлгүүд болон үндэсний, хэлний, соёлын, бэлгийн цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, орлого багатай иргэд зэрэг дуу хоолойгоо хүргэж, шийдвэр гаргахад оролцож чадахгүй байгаа бүлгүүдийг эрх мэдэлжүүлэх зорилгоор боловсролын тогтолцоо, бодлогод хяналт шинжилгээ, үнэлгээ хийх чадавхыг бүрдүүлэх, нөлөөлөх ур чадвараа дээшлүүлэх шаардлагыг ухамсарлан;

Хүний эрх, жендэрийн тэгш эрх, үл ялгаварлан гадуурхах, хүчирхийллээс ангид, хүлээцтэй байх, нээлттэй, ил тод, хариуцлагатай байх зарчмыг баримтлан;

Монгол улсад боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах, төсвийг хянах, хариуцлага шаардах, бодлогод нөлөөлөх үндэсний кампанит ажил зохион байгуулах зорилгоор эвсэн нэгдсэнээ тунхаглаж байна.